

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын
 2024 оны 12 дугаар сарын 13 ны өдрийн
 02/06 дүгээр албан бичгийн нэгдүгээр
 хавсралт



“АЛСЫН ХАРАА – 2050” МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ
 БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРААС ХАРИУЦАН ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАН

2024 оны 12 дугаар сарын 13

Улаанбаатар хот

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр	Зорилтот түвшин үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин үр дүн	Хэрэгжилтийн хувь
	1	2	3	4	5	6	7
ЕС.УЛААНБААТАР БА ДАГУУЛ ХОТ							
1	9.1.Иргэдийнхээ хөгжих боломжийг хангасан хөдөлмөрийн үнэлэмж өндөртэй эрүүл чийрэг, бүтээгч, оюунлаг иргэдтэй хот болно.	9.1.18.Хотын хэмжээнд бүх насны иргэдэд үйлчлэх спортын зориулалтын стандарт талбайн хүртээмжийг нэмэгдүүлж, биеийн тамир, спортын барилга байгууламжийг төлөвлөн байгуулна.	2020-2050	-	Төрөлжсөн талбайн тоог 108 болгоно. Спортын барилга байгууламжийн хүртээмжийг 64 мкв-д хүргэнэ.	Стандарт шаардлагад нийцсэн спортын зориулалтын гадна талбай 2019 онд 101 байсан бол 2021 онд суурь судалгааг хийж Нийслэлийн Засаг даргын удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж цаашид нэмэгдүүлэх чиглэл өгөгдсөний дагуу 2022 онд 4-өөр нэмэгдэж (Хан-уул дүүргийн 8 дугаар хороонд хөл бөмбөгийн талбай бүхий техникийн төв, 34, 52, 2-р сургуулиудын гадна талбайг хөл бөмбөгийн хиймэл зүлэг болон бусад тоноглолоор тохижуулсан) 105 болсон. 2023 онд 36 талбай (Нийслэлийн Хот тохижилтын газар хариуцан 3х3 сагсан бөмбөгийн 34 талбайг ашиглалтад оруулсан бол 57, 67-р сургуулийн спорт талбайг шинэчлэн тохижуулсан.)-аар нэмэгдэж 141 болсон. 2024 онд 62 (Нийслэлийн Хот тохижилтын газар хариуцан ажиллаж 3х3 сагсан бөмбөгийн 40 талбайг, Нийслэлийн Захирагчийн ажлын албанаас 20 байршилд байгуулсан. Мөн 22, 169-р сургуулийг биеийн тамирын гадна талбайг байгуулан ашиглалтад оруулсан)-аар 203 болсон. Нийслэлийн хэмжээнд 1000 хүнд оногдох спортын барилга байгууламжийн хүртээмж 2021 онд 61м ² , 2022 онд 62м ² , 2023 онд 63,5м ² , 2024 онд 65мкв-д хүрсэн байна.	100%
						Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/1046 дугаар “Газар эзэмших эрх олгох тухай” захирамжаар Хан-Уул дүүргийн 8 дугаар хорооны нутаг дэвсгэрт	

2.	<p>9.3.Орон зайн оновчтой төлөвлөлт бүхий суурьшлын зөв тогтолцоотой, эрчимтэй, хөгжиж байгаа дагуул хотуудтай олон улсад өрсөлдөгч метрополитан болж хөгжинэ.</p>	<p>9.3.48.Тив дэлхийн аварга шалгаруулах тэмцээн, томоохон спортын наадмыг зохион байгуулах шаардлага хангасан, олон улсын жишигт нийцсэн 30,000-40,000 хүний суудалтай цэнгэлдэх хүрээлэн барьж байгуулна.</p>	2021-2030	-	-	<p>байрших 30.0 га газарт “Үндэсний төв цэнгэлдэх хүрээлэн” байгуулах зориулалтаар 15 жилийн хугацаатай газар эзэмших эрхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт олгосон боловч тухайн газар нь Байгаль орчны яаманд олгосон газруудтай давхцалтай байсан тул Монгол Улсын Шадар сайдын 2021 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 07 тоот тушаал, Барилга хот байгуулалтын сайдын 2021 оны 02 дугаар сарын 10-ны 36 дугаар тушаалаар дэд ажлын хэсгүүд байгуулагдан газрын маргаан, зөрчлийг шийдвэрлэхээр ажиллаж байгаа ч газрын асуудал эцэслэн шийдэгдээгүйн улмаас зураг төсөв эцэслэн батлагдах, хөрөнгө шийдвэрлэх боломжгүй болсон. Үндэсний төв цэнгэлдэх хүрээлэн байгуулах талаар авах арга хэмжээний тухай Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 315 дугаар тогтоол гарч хэрэгжиж байсан бөгөөд 2023 оны 162 дугаар тогтоолоор тус тогтоол хүчингүй болгосон байна. Олон Улсын жишигт нийцсэн 30.000-40.000 хүний суудалтай цэнгэлдэх хүрээлэн шинээр барих асуудал нь бодлогын баримт бичгүүдэд туссан 2020-2024 оны хүрэх түвшиндөө бүрэн хүрэх боломжгүй байгаа тул бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан заалтуудыг хасах санал гарган 2023 оны 3/222 тоот албан бичгээр НЗДТГ-т хүргүүлж ажилласан.</p>	30%
3.	<p>9.5.Үндэсний онцлог бүхий аялал жуулчлал, соёлын үйлчилгээ, үйлдвэрлэлийг бий болгосон, Зүүн хойд азийн тээвэр, логистикийн болон олон улсын харилцааны зангилаа төв болсон дагуул хотуудыг хөгжүүлнэ.</p>	<p>9.5.14.Олон улс, тив, дэлхийн томоохон наадмуудыг хүлээн авч зохион байгуулах шаардлага хангасан спортын барилга байгууламжийг барина.</p>	2021-2030	Улсын төсвөөс 1,748.0	Налайх дүүргийн спорт цогцолборыг ашиглалтад оруулна.	<p>2024 оны жилийн эцсийн байдлаар нийслэлийн хэмжээнд 1000 хүнд оногдох спортын барилга байгууламжийн хүртээмж 65мкв байна. 2024 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийслэлийн Налайх, Багахангай, Баянзүрх дүүргийн спорт цогцолборуудыг ашиглалтад оруулахаар төлөвлөж Багахангай дүүргийн 2 дугаар хорооны спорт цогцолборын барилгын ажлын гүйцэтгэгчээр “Алтан шар говь” ХХК шалгарч 2022 онд 500.0 сая, 2023 онд 815.6 сая, 2024 онд 1,100.0 сая төгрөгийн санхүүжилтээр барилгын ажлын 70 хувийг гүйцэтгэж карказ, гадна өрлөгийн ажил дууссан, сантехникийн ажил эхэлсэн бол Налайх дүүргийн 1-р хорооны нутаг дэвсгэрт баригдаж буй спорт цогцолборын барилгын ажлын гүйцэтгэгчээр “Бүрд констракшн” ХХК ажиллаж 15.0 тэрбум төгрөгийн төсөвт өртгөөр байгуулж 100 хувьтай улсын комиссын шийдвэрээр дуусгавар болж ашиглалтад орсон. Баянзүрх дүүргийн спортын ордны бүтээн байгуулалтын ажил</p>	100%

					85 хувьтай 2024 онд 2.58 тэрбум төгрөг тусгаж үерийн далангийн ажил үргэлжилж байна.	
4.	9.1.Иргэдийнхээ хөгжих боломжийг хангасан хөдөлмөрийн үнэлэмж өндөртэй эрүүл чийрэг, бүтээгч, оюунлаг иргэдтэй хот болно	9.1.17.Орчин үеийн техник, технологийн дэвшлийг биеийн тамир, спортын ажил, үйлчилгээнд нэвтрүүлснээр бүх насны иргэд хиймэл оюун ухаанд суурилсан спортын зөвлөн туслах үйлчилгээ авах боломжийг бүрдүүлнэ.	2021-2030		Биеийн тамир, спортын үйлчилгээг цахимаар иргэд, олон нийтэд үзүүлж буй цахим үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх чиглэлээр “Онлайн бизнес төв” платформын үйлчилгээ эрхлэх бүртгэлийн систем /http://service.ulaanbaatar.mn/home/-ийн 74 нэр бүхий үйлчилгээнд биеийн тамир, спортын салбарын бассейн, фитнес, спининг, аэробик, иог, бүжгийн клуб, боулинг, бильярд гэсэн 5 чиглэлийн үйлчилгээ орсон бөгөөд 2024 оны жилийн эцсийн байдлаар 20 аж ахуйн нэгж байгууллага, 21 иргэнээс нийт 49-н хүсэлт бүртгүүлснээс зөвшөөрсөн 18, шилжүүлсэн 5, буцаасан 20, татгалзсан 0, судлагдаж байгаа 6 байна.	90%
Хэрэгжилтийн дундаж 80 хувьтай үргэлжилж байна.						

ТАНИЛЦАН:
НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТ, САНХҮҮГИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:
ЭРХ ЗҮЙ, ТОГТООЛ ШИЙДВЭР, ТАЙЛАН
МЭДЭЭ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН



С.САРАНЦЭЦЭГ

М.ЦОГЗОЛМАА

Н.СҮНЖИДМАА

НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗАР

ИЛТГЭХ ХУУДАС

2024 оны 12 дугаар сарын 13

Улаанбаатар хот

“АЛСЫН ХАРАА – 2050” МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН
БАРИМТ БИЧИГТ БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРААС ХАРИУЦАН
ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТЭД
ХЯНАЛТ–ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТУХАЙ

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО:

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт Нийслэлийн Биеийн тамир, спортын газраас хариуцан хэрэгжүүлэх арга хэмжээний 2024 оны жилийн эцсийн байдлаар хэрэгжилтийг тухайн онд тавьсан зорилт, хүрэх түвшин, шалгуур үзүүлэлттэй харьцуулан тооцож, үр дүнг үнэлэн, дүгнэлт өгч, удирдлагыг үнэн бодит мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, хариуцлагыг сайжруулахад хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго оршино.

ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ:

“Алсын хараа–2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт Нийслэлийн Биеийн тамир, спортын газраас хариуцан хэрэгжүүлэх 3 зорилт 4 арга хэмжээний хэрэгжилтийг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын дагуу “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ийн 6.2.1, 6.2.2-т заасан аргачлалын дагуу тооцож, арга хэмжээний дундаж үнэлгээгээр тус журмын 6.2.3 дахь заалтын дагуу шилжүүлэн тооцсон.

ГУРАВ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН:

“Алсын хараа–2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт Нийслэлийн Биеийн тамир, спортын газраас хариуцан хэрэгжүүлэх 3 зорилт 4 арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

(Хүснэгт-1)

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зорилтот түвшин үр дүнгийн үзүүлэлт 2024 он	Хүрсэн түвшин үр дүн	ХШҮ-ний хувь
	1	2	3	4	5	6
ЕС.УЛААНБААТАР БА ДАГУУЛ ХОТ						
1	9.1.Иргэдийнхээ хөгжих боломжийг хангасан хөдөлмөрийн үнэлэмж өндөртэй эрүүл чийрэг,	9.1.17.Орчин үеийн техник, технологийн дэвшлийг биеийн тамир, спортын ажил, үйлчилгээнд нэвтрүүлснээр бүх насны иргэд хиймэл оюун ухаанд суурилсан спортын зөвлөн туслах үйлчилгээ авах боломжийг бүрдүүлнэ.	2021-2030	-	“Онлайн бизнес төв” платформын үйлчилгээ эрхлэх бүртгэлийн систем / http://service.ulaanbaatar.mn/home/ -ийн 5 чиглэлийн үйлчилгээ үзүүлсэн.	90

2.	бүтээгч, оюунлаг иргэдтэй хот болно.	9.1.18.Хотын хэмжээнд бүх насны иргэдэд үйлчлэх спортын зориулалтын стандарт талбайн хүртээмжийг нэмэгдүүлж, биеийн тамир, спортын барилга байгууламжийг төлөвлөн байгуулна.	2020-2050	Төрөлжсөн талбайн тоог 106 болгоно. Спортын барилга байгууламжийн хүртээмжийг 63 мкв-д хүргэнэ.	2024 онд нийслэлийн хэмжээнд 1000 хүнд оногдох спортын барилга байгууламжийн хүртээмж 63,5мкв болсон байна.	100
3.	9.3.Орон зайн оновчтой төлөвлөлт бүхий суурьшлын зөв тогтолцоотой, эрчимтэй, хөгжиж байгаа дагуул хотуудтай олон улсад өрсөлдөгч метрополитан болж хөгжинө.	9.3.48.Тив дэлхийн аварга шалгаруулах тэмцээн, томоохон спортын наадмыг зохион байгуулах шаардлага хангасан, олон улсын жишигт нийцсэн 30,000-40,000 хүний суудалтай цэнгэлдэх хүрээлэн барьж байгуулна.	2021-2030	-	НЗДТГ-т албан бичиг хүргүүлж ажилласан бөгөөд өөрсдөөс хамаарах шийдвэрийг гаргаж, дээд шатны байгууллагад өргөн барьсан.	30
4.	9.5.Үндэсний онцлог бүхий аялал жуулчлал, соёлын үйлчилгээ, үйлдвэрлэлийг бий болгосон, Зүүн хойд азийн тээвэр, логистикийн болон олон улсын харилцааны зангилаа төв болсон дагуул хотуудыг хөгжүүлнэ.	9.5.14.Олон улс, тив, дэлхийн томоохон наадмуудыг хүлээн авч зохион байгуулах шаардлага хангасан спортын барилга байгууламжийг барина.	2021-2030	Налайх дүүргийн спорт цогцолборыг ашиглалтад оруулна.	Налайх дүүргийн спорт цогцолбор 100 хувь ашиглалтад оруулсан.	100
80 хувьтай буюу "тодорхой үр дүнд хүрсэн" гэж үнэлэв.						

ДҮГНЭЛТ:

"Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт Нийслэлийн Биеийн тамир, спортын газраас хариуцан хэрэгжүүлэх 3 зорилт 4 арга хэмжээний хэрэгжилтийг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын дагуу "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ийн 6.2.1, 6.2.2-т заасан аргачлалын дагуу тооцож, арга хэмжээний дундаж үнэлгээгээр тус журмын 6.2.3 дахь заалтын дагуу шилжүүлэн тооцож 80 хувьтай буюу "тодорхой үр дүнд хүрсэн" гэж үнэллээ.

ТАНИЛЦСАН:

НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ **С.САРАНЦЭЦЭГ**

ХЯНАСАН:

ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТ, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА **М.ЦОГЗОЛМАА**

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

ХҮНИЙ НӨӨЦ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН

Б.ОЮУНТУЯА



Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын
 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн
 02/261 дүгээр албан бичгийн
 хоёрдугаар хавсралт



МОНГОЛ УЛСЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛД
 БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ЧИГЛЭЛЭЭР ТУССАН АЖЛЫН 2021, 2022, 2023, 2024 ОНЫ
 ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

2024 оны 12 дугаар сарын 13

Улаанбаатар хот

№	Үндэслэж байгаа бодлогын баримт бичиг	2021-2024 оны эхний хагас жилийн байдлаар зарцуулсан төсөв (сая.төг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин		2024 оны зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу гүйцэтгэлийн хувь (хүрээгүй бол шалтгаан нөхцөл тайлбар)
				он	түвшин		
1		2	3	4	5	6	7
Эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг Зорилт 3.5.Биеийн тамир, спортын чанар, хүртээмжтэй, үр дүнтэй тогтолцоог бүрдүүлнэ.							
1	3.5.1.хүн амд биеийн тамир, спортын үйлчилгээ үзүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлд суурилсан нээлттэй, уян	-	Нийслэлийн хэмжээнд сорилд хамрагдсан иргэдийн бие бялдрын хөгжлийн	2019	53% /А, В, С үнэлгээ авсан/	60% /А, В, С үнэлгээ авсан/	2021 онд Коронавируст халдвар /Ковид-19/-ын тархалттай холбогдуулан хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил авах ажил хийгдээгүй. 2022 онд 24 төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллаж нийслэл, дүүргийн хэмжээнд 237 спортын уралдаан тэмцээнийг зохион байгуулж 3517 багийн 180,661 тамирчдыг оролцуулсан бол нийтийг хамарсан 340 арга хэмжээнд 26,054 байгууллагын давхардсан тоогоор 1,170,073 иргэнийг хамруулснаар хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилд хамрагдсан иргэдийн 30 хувь нь А,В,С үнэлгээ авсан.


	хатан тогтолцоог бүрдүүлнэ.		суурь үзүүлэлт				<p>2023 онд 65 төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллаж 272 удаагийн уралдаан тэмцээнийг зохион байгуулж 3113 багийн 164,032 тамирчдыг оролцуулсан бол нийтийг хамарсан 368 арга хэмжээнд 9930 байгууллагын 873,313 иргэдийг хамруулснаар хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилд хамрагдсан иргэдийн 82% нь А, В, С үнэлгээ авсан үзүүлэлттэй байна.</p> <p>2024 онд бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил авах ажлыг нийслэлийн хэмжээнд IV-VI, IX-XII саруудад зохион байгуулж 193,000 иргэн хамрагдсан бол сорилд хамрагдсан нийт иргэдийн 80 хувь нь А, В, С үнэлгээ авсан үзүүлэлттэй үнэлэгдсэн. 2024 онд Баянгол, Налайх дүүрэгт сорилын шинэ төв байгуулагдсан. Энэ төв нь иргэдийн бие бялдрын түвшин тогтоох сорилыг орчин үеийн тоног төхөөрөмжөөр авах бөгөөд бие бялдрын ажиллах чадвар, бүтцийг тодорхойлох юм.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт 100%</p>
2	3.5.2.иргэдэд үйлчлэх спортын зориулалтын стандарт талбайн хүртээмж нэмэгдэнэ.	-	Төрөлжсөн талбайн тоо	2019	94	108	<p>Стандарт шаардлагад нийцсэн биеийн тамир, спортын талбайг нэмэгдүүлэх ажлын хүрээнд 2021 онд Баянгол, Сонгинохайрхан, Чингэлтэй дүүргийн орон сууц, гэр хорооллын дунд 3*3 сагсан бөмбөгийн 7 талбай байгуулагдаж төрөлжсөн талбайн тоо 101 болж өссөн.</p> <p>2022 онд Хан-Уул дүүргийн 8-р хороонд Хөлбөмбөгийн талбай бүхий техникийн төв, Сүхбаатар дүүргийн 2-р сургууль, Хан – Уул дүүргийн 34, 52-р сургуулиудын гаднах талбай зэрэг 3 – аар нэмэгдэж 104 болсон.</p> <p>2023 онд 36 талбайгаар нэмэгдэж 140 буюу Чингэлтэй дүүргийн 57, Сонгинохайрхан дүүргийн 67-р сургуулийн спорт талбай мөн Нийслэлийн Засаг даргын санаачилгаар 3x3 сагсан бөмбөгийн</p>

							<p>34 талбайг 2022 оноос тохижуулж эхлэн 2023 оны 06 дугаар сард ашиглалтад оруулсан.</p> <p>Нийслэлийн нутаг дэвсгэр дээр биеийн тамир, спортын зориулалтын гадна талбай 2024 онд 201 байна. Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/490 дүгээр захирамжийн хүрээнд Нийслэлийн Хот тохижилтын газраас 2023-2024 онд 3x3 сагсан бөмбөгийн 40 талбайг байгуулж ашиглалтад оруулсан. Мөн Нийслэлийн Захирагчийн ажлын албанаас 3x3 сагсан бөмбөгийн талбай 20 байршилд байгуулсан.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт 100%</p>
3	3.5.3.нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, аж төрөх ёсны салшгүй хэсэг болгон хөгжүүлнэ.	Улсын төсвөөс 88,4 Нийслэлийн төсвөөс 1,650.3	Хамрагдсан иргэдийн тоо	2019	725.196	888.451	<p>2021 онд нийслэл, дүүргийн хэмжээнд нийтийг хамарсан 116 арга хэмжээг цахим болон практик хэлбэрээр зохион байгуулж 2876 байгууллагын 635.486 иргэнийг хамруулсан бол 2022 онд коронавируст халдвар (ковид-19)-ын цар тахлын дараа иргэдийн бие бялдрыг чийрэгжүүлэх, хөдөлгөөний хомсдолоос сэргийлэх эрэлт хэрэгцээнд тулгуурлан нийтийг хамарсан 340 арга хэмжээ зохион байгуулж 26,054 байгууллагын давхардсан тоогоор 1,170,073 иргэнийг хамруулж суурь төвшнөөс 38 хувиар өссөн.</p> <p>2023 онд нийтийг хамарсан 24 арга хэмжээг зохион байгуулж 2481 байгууллагын 416,000 иргэнийг хамруулсан бол нийслэл, дүүргийн хэмжээнд 368 арга хэмжээнд 9930 байгууллагын 873,313 иргэнийг хамруулсан.</p> <p>Нийслэлийн Биеийн тамир, спортын газраас 2024 онд нийтийг хамарсан 17 үйл ажиллагаа зохион байгуулж 1995 байгууллага, 450.200 иргэнийг хамруулсан бол нийслэл, дүүргийн хэмжээнд 2024 онд нийтийн биеийн тамирын 345 арга хэмжээ зохион байгуулж 8909 байгууллагын 888,500 иргэнийг хамруулсан байна.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт 100%</p>

4	3.5.4.мэргэж-лийн спортыг дэмжиж, тамирчдын чадвар, амжилт дээшилсэн байна.	-	Өсвөрийн шигшээ багуудын спортын төрөл	2019	22	25	<p>2021 онд 9 дүүргийн Засаг даргын дэргэд өсвөрийн шигшээ багуудыг спортын 24 төрлөөр 82 дасгалжуулагч 1814 тамирчдын бүрэлдэхүүнтэй сургалт, дасгалжуулалтад хамруулсан бол 2022 онд 25 төрлөөр 65 багт 101 дасгалжуулагч, 2856 тамирчдын бүрэлдэхүүнтэй сургалт, дасгалжуулалтад хамруулсан.</p> <p>2023 онд 9 дүүргийн Засаг даргын дэргэдэх өсвөр үеийн шигшээ багыг спортын 28 төрлөөр 105 дасгалжуулагч 2944 тамирчдын бүрэлдэхүүнтэй байгуулж бэлтгэл, сургуулилт, дасгалжуулалтад хамруулсан.</p> <p>2024 онд Засаг даргын дэргэдэх Өсвөрийн шигшээ багийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулж спортын 28 төрөлд 109 багт 109 дасгалжуулагчтай 3525 тамирчдыг бэлтгэл сургуулилтад хамруулж байна.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт 100%</p>
5	9.1.1.Нийгмийн үйлчилгээний байгууллагуудын (сургууль, цэцэрлэг, эрүүл мэнд, биеийн тамир, спортын байгууллага, залуучууд хөгжлийн төв, хүүхэд хамгаалах төв, асрамжийн газар гэх мэт) хүчин чадал, хүртээмжийг нэмэгдүүлсэн байна.	-	Спортын барилга байгууламжийн хүртээмж мкв	2019	60	64	<p>Биеийн тамир, спортын барилга байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлэн 2021 онд Чингэлтэй дүүргийн спорт цогцолбор, Хан-Уул дүүрэгт битүү дээвэртэй өвлийн спортын ордон, Баянгол дүүргийн 4-р сургуулийн спорт заал, Багануур дүүргийн 1 хороонд спорт заал, 20 дугаар сургуульд усан бассейн шинээр ашиглалтад орж биеийн тамир, спортын барилга байгууламжийн хүртээмж 1м²-аар нэмэгдсэн бол 2022 онд Баянгол дүүргийн 15-р хороо хороонд 650 хүний суудалтай спорт цогцолбор, 3-р хороонд 3000 хүний суудалтай "UG Arena" спорт цогцолбор тус тус ашиглалтад орж хүртээмжийг 1 мкв-аар нэмэгдүүлж 62 м² болсон. Нийслэлийн хэмжээнд 1000 хүнд оногдох спортын барилга байгууламжийн хүртээмж 2023 онд 63,5мкв болж өссөн. Үүнд Хан-уул дүүргийн 1 дүгээр хороо нүхтийн зам дагуу 508 м² талбай бүхий MINT sport Club, Хан-уул дүүргийн 2 дугаар хороо Говийн зам</p>

						<p>дагуу 600 м² талбай бүхий В3 NBA спорт заал, Хан-уул дүүргийн 3 дугаар хороонд 833 м² талбай бүхий Emart спорт заал, Хан-Уул дүүргийн 1 дүгээр хороонд 812 мкв талбай бүхий Наадам спорт клуб, Сүхбаатар дүүргийн 11-р хороо 672 м² талбай бүхий Хангай хотхонд Shine sport center спорт заал, Сонгинохайрхан дүүргийн 20-р хороонд 540 м² талбай бүхий "ОБ" спорт заал, Сонгинохайрхан дүүргийн 4 дүгээр хороонд Толгойт хөгжлийн төвийн 1 давхарт спорт заал, Сонгинохайрхан дүүргийн 29-р хороонд 800 м² талбайтай "City" спорт заал ашиглалтад орсон.</p> <p>2024 онд биеийн тамир, спортын зориулалтын гадна талбай 201 буюу Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/490 дүгээр захирамжаар Нийслэлийн Хот тохижилтын газар хариуцан ажиллаж 40 талбай ашиглалтад орсон байна. Мөн Нийслэлийн Захирагчийн ажлын албанаас 3x3 сагсан бөмбөгийн талбай 20 байршилд байгуулсан.</p> <p>Нийслэлийн хэмжээнд 1000 хүнд оногдох спортын барилга байгууламжийн хүртээмж 2021 онд 61м², 2022 онд 62м², 2023 онд 63,5м², 2024 онд 65мкв байна.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт 100%</p>
Хэрэгжилтийн дундаж хувь						100%

ТАЙЛАНТАЙ ТАНИЛЦСАН:
 НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР СПОРТЫН
 ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙН ТҮР
 ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
 ТАЙЛАН ХЯНАСАН:
 ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТ, САНХҮҮГИЙН
 ХЭЛТСИЙН ДАРГА
 ТАЙЛАН НЭГТГЭСЭН:
 ЭРХ ЗҮЙ, ТОГТООЛ ШИЙДВЭР
 ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН



С.САРАНЦЭЦЭГ

М.ЦОГЗОЛМАА

Н.СҮНЖИДМАА

НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗАР

ИЛТГЭХ ХУУДАС

2024 оны 12 дугаар сарын 13

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛД
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ЧИГЛЭЛЭЭР ТУССАН АЖЛЫН 2021-2024 ОНЫ
ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТУХАЙ

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО:

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд Биеийн тамир, спортын чиглэлээр туссан ажлын 2021-2024 оны хэрэгжилтэд тухайн онд тавьсан зорилт, хүрэх түвшин, шалгуур үзүүлэлттэй харьцуулан тооцож, үр дүнг үнэлэн, дүгнэлт өгч, удирдлагыг үнэн бодит мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, хариуцлагыг сайжруулахад хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго оршино.

ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ:

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд Биеийн тамир, спортын чиглэлээр туссан ажлын 2021-2024 оны хэрэгжилтийг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын дагуу “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ийн 6.2.1, 6.2.2-т заасан аргачлалын дагуу тооцож, арга хэмжээний дундаж үнэлгээгээр тус журмын 6.2.3 дахь заалтын дагуу шилжүүлэн тооцсон.

ГУРАВ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН:

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд Биеийн тамир, спортын чиглэлээр туссан ажлын 2021-2024 оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

(Хүснэгт-1)

№	Үндэслэж байгаа бодлогын баримт бичиг	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин		2024 оны зорилтот түвшин	Хүрсэн түвшин	ХШҮ-ний хувь
			он	түвшин			
1	2	3	4	5	6	7	8
Эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг Зорилт 3.5.Биеийн тамир, спортын чанар, хүртээмжтэй, үр дүнтэй тогтолцоог бүрдүүлнэ.							
1.	3.5.1.хүн амд биеийн тамир, спортын үйлчилгээ үзүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлд суурилсан нээлттэй, уян хатан тогтолцоог бүрдүүлнэ.	Нийслэлийн хэмжээнд сорилд хамрагдсан иргэдийн бие бялдрын хөгжлийн суурь үзүүлэлт	2019	53% /А, В, С үнэлгээ авсан/	60% /А, В, С үнэлгээ авсан/	2021 онд /Ковид-19/-ын тархалттай холбогдуулан сорил авах ажил хийгдээгүй. 2022 онд 80 хувь 2023 онд 82 хувь 2024 онд 80 хувь	100
2.	3.5.2.иргэдэд үйлчлэх спортын зориулалтын стандарт талбайн хүртээмж нэмэгдэнэ.	Төрөлжсөн талбайн тоо	2019	94	108	2021 онд 101 2022 онд 104 2023 онд 140 2024 онд 201	100
3.	3.5.3.нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын	Хамрагдсан				2021 онд 635.486 2022 онд 26,054	100

	хэв маяг, аж төрөх ёсны салшгүй хэсэг болгон хөгжүүлнэ.	иргэдийн тоо	2019	725,196	888.451	2023 онд 856,000 2024 онд 888,500	
4.	3.5.4. мэргэжлийн спортыг дэмжиж, тамирчдын чадвар, амжилт дээшилсэн байна.	Өсвөрийн шигшээ багуудын спортын төрөл	2019	22	25	2021 онд 24 2022 онд 25 2023 онд 28 2024 онд 28	100
5.	9.1.1. Нийгмийн үйлчилгээний байгууллагуудын (сургууль, цэцэрлэг, эрүүл мэнд, биеийн тамир, спортын байгууллага, залуучууд хөгжлийн төв, хүүхэд хамгаалах төв, асрамжийн газар гэх мэт) хүчин чадал, хүртээмжийг нэмэгдүүлсэн байна.	Спортын барилга байгууламжийн хүртээмж мкв	2019	60	64	2021 онд 61 мкв 2022 онд 62 мкв 2023 онд 63,5 мкв 2024 онд 65 мкв	100

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд Биеийн тамир, спортын чиглэлээр туссан 1 зорилт 5 арга хэмжээний 2021-2024 оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 100 хувьтай буюу "үр дүнтэй" байна.

ДӨРӨВ.ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ДҮГНЭЛТ:

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд Биеийн тамир, спортын чиглэлээр туссан 1 зорилт 5 ажлын 2021-2023 оны хэрэгжилтэд 2023 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын дагуу "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 6.2.1, 6.2.2-т заасан аргачлалын дагуу тооцож, зорилт, арга хэмжээний дундаж үнэлгээгээр бодлогын зорилго, зорилтын хэрэгжилтийг тус журмын 6.2.3 дахь заалтын дагуу шилжүүлэн тооцож зорилт, арга хэмжээ нь оновчтой тодорхойлогдсон, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн, үр дүн гарсан 100 хувьтай буюу "үр дүнтэй" гэж үнэллээ.

ТАНИЛЦСАН:

НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ **С.САРАНЦЭЦЭГ**

ХЯНАСАН:

ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТ, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА **М.ЦОГЗОЛМАА**

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

ХҮНИЙ НӨӨЦ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН

Б.ОЮУНТУЯА



Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын
 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн
 02/2024 дүгээр албан бичгийн
 гуравдугаар хавсралт



МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНД БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ЧИГЛЭЛЭЭР ТУССАН АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

2024 оны 12 дугаар сарын 13

Улаанбаатар хот

Дугаар	ХБТББ-т тусгагдсан зорилт/үйл ажиллагаа	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Үндсэн хэрэгжүүлэх байгууллага	Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ (сая.төгрөг)	Суурь түвшин (2021 он)	2024 оны зорилтот түвшин, үр дүн (хөрөнгийн хэмжээ эх үүсвэр)			Хэрэгжилтийн явц	Хувь
								Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв (сая.төг)	Төсвийн гүйцэтгэл (сая.төг)		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	
1.	3.3.3.Нийтийн биеийн тамир, спортын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.	3.3.3.2. Дотоодын болон олон улсын тэмцээн, наадам	2024 он	Биеийн тамир, спортын Улсын хороо	-	-	Нийтийн биеийн тамирын 116 арга хэмжээг зохион байгуулж 2876 багийн 635,486 иргэн хамруулсан	Нийтийн хамарсан 888,451 иргэнийг, спортын уралдаан	Улсын төсөв 145,0	Улсын төсвөөс 58,5 Нийс	Нийслэлийн Биеийн тамир, спортын газраас 2024 онд нийтийг хамарсан 17 үйл ажиллагаа зохион байгуулж 1995 байгууллага, 450.200 иргэнийг хамруулсан бол нийслэл, дүүргийн хэмжээнд 2024 онд нийтийн биеийн тамирын 345 арга хэмжээ зохион байгуулж 8909 байгууллагын 888,500 иргэнийг хамруулсан байна. Төр, хувийн хэвшлийн хамтын	100%

		зохион байгуулах					бол спортын 34 төрлөөр зохион байгуулж 7086 тамирчин хамрагдсан.	тэмцээнд 7,250		лэлийн төсвөөс 694,8	ажиллагааг сайжруулах, спортын холбоодын үйл ажиллагааг дэмжих зорилгоор 2024 оны жилийн эцсийн байдлаар 27 спортын холбоотой ажил гүйцэтгэх, хамтран ажиллах гэрээ байгуулж 129.070.000 төгрөгийн дэмжлэг үзүүлж Улаанбаатар хотын аварга шалгаруулах тэмцээнийг спортын 23 төрлөөр, даншиг надам 2 төрөл, нүүдэлчин дэлхийн соёлын фестивалийг зохион байгуулж 301 байгууллагын 7888 тамирчид оролцсон.	
2.		3.3.3.3. Биеийн тамир спортын байгуу ламж, талбай,	2024 он	Биеийн тамир, спортын Улсын хороо	-	-	Сорилд хамрагдсан иргэдийн бие бялдрын хөгжлийн суурь	Сорилд хамрагд сан иргэдийн бие бялдрын хөгжлийн	-	-	2024 онд биеийн тамир, спортын зориулалтын гадна талбай 201 буюу Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/490 дүгээр захирамжаар Нийслэлийн Хот тохижилтын газар хариуцан ажиллаж 40 талбай ашиглалтад орсон байна. Мөн Нийслэлийн Захирагчийн ажлын албанаас 3x3 сагсан бөмбөгийн талбай 20 байршилд байгуулсан. Нийслэлийн хэмжээнд 1000 хүнд оногдох спортын барилга байгууламжийн хүртээмж 2021 онд 61м ² , 2022 онд 62м ² , 2023 онд 63,5м ² . 2024 онд 65мкв байна. Монгол Улсын	100%

		тоног төхөөрөмж өөр хангах.				үзүүлэлт 85 хувь	суурь үзүүлэлт 65 хувь			Ерөнхийлөгчийн 2010 оны 53 дугаар зарлигийн дагуу бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил авах ажлыг нийслэлийн хэмжээнд 2024 оны IV-VI, IX-XII саруудад зохион байгуулж 193,000 иргэн хамрагдсан бол сорилд хамрагдсан нийт иргэдийн 80 хувь нь А, В, С үнэлгээ авсан үзүүлэлттэй үнэлэгдсэн. 2024 онд Баянгол, Налайх дүүрэгт сорилын шинэ төв байгуулагдсан.
Хэрэгжилтийн хувь										100%

ТАНИЛЦСАН:
НИЙСЛЭЛИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

С.САРАНЦЭЦЭГ

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТ, САНХҮҮГИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

М.ЦОГЗОЛМАА

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:
ЭРХ ЗҮЙ, ТОГТООЛ ШИЙДВЭР
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Н.СҮНЖИДМАА



НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗАР

ИЛТГЭХ ХУУДАС

2024 оны 12 дугаар сарын 13

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНД БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ЧИГЛЭЛЭЭР ТУССАН АРГА ХЭМЖЭЭНИЙ 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТУХАЙ

ЗОРИЛГО:

Монгол улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд биеийн тамир, спортын чиглэлээр тусгагдсан 2 арга хэмжээний төлөвлөгөөний 2024 оны жилийн эцсийн үйл ажиллагааны хэрэгжилтийг тухайн онд тавьсан зорилт, хүрэх түвшин, шалгуур үзүүлэлттэй харьцуулан тооцож, үр дүнг үнэлэн, дүгнэлт өгч, зөвлөмж боловсруулж, удирдлагыг үнэн бодит мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, хариуцлагыг сайжруулахад хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго оршино.

Монгол улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд биеийн тамир, спортын чиглэлээр тусгагдсан зорилт, арга хэмжээний 2024 оны жилийн эцсийн үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн ажлын үр дүнг танилцуулж байна.

АРГА ЗҮЙ:

Монгол улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд биеийн тамир, спортын чиглэлээр тусгагдсан 1 арга хэмжээний хэрэгжилтийг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын дагуу “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ийн 6.2.1, 6.2.2-т заасан аргачлалын дагуу тооцож, зорилт, арга хэмжээний дундаж үнэлгээгээр бодлогын зорилго, зорилтын хэрэгжилтийг тус журмын 6.2.3 дахь заалтын дагуу шилжүүлэн тооцож 70 хувьтай буюу “тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэллээ.

ТУССАН АРГА ХЭМЖЭЭ:

3.3.3.2. Дотоодын болон олон улсын тэмцээн, наадам зохион байгуулах ажлын хүрээнд: Нийтийг хамарсан 17 үйл ажиллагаа зохион байгуулж 1995 байгууллага, 450.200 иргэнийг хамруулсан бол нийслэл, дүүргийн хэмжээнд 2024 онд нийтийн биеийн тамирын 345 арга хэмжээ зохион байгуулж 8909 байгууллагын 888,500 иргэнийг хамруулсан байна.

Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг сайжруулах, спортын холбоодын үйл ажиллагааг дэмжих зорилгоор 2024 оны жилийн эцсийн байдлаар 27 спортын холбоотой ажил гүйцэтгэх, хамтран ажиллах гэрээ байгуулж 129.070.000 төгрөгийн дэмжлэг үзүүлж Улаанбаатар хотын аварга шалгаруулах тэмцээнийг спортын 23 төрлөөр, даншиг наадам 2 төрөл, нүүдэлчин дэлхийн соёлын фестивалийг зохион байгуулж 301 байгууллагын 7888 тамирчдыг хамруулснаар шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн гэж үзээд 100 хувьтай гэж үнэллээ.

3.3.3.3. Биеийн тамир спортын байгууламж, талбай, тоног төхөөрөмжөөр хангах ажлын хүрээнд: Биеийн тамир, спортын зориулалтын гадна талбай 201 буюу Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/490 дүгээр захирамжаар Нийслэлийн Хот тохижилтын газар хариуцан ажиллаж 40 талбай ашиглалтад орсон. Мөн Нийслэлийн Захирагчийн ажлын албанаас 3х3 сагсан бөмбөгийн талбай 20 байршилд байгуулсан.

Нийслэлийн хэмжээнд 1000 хүнд оногдох спортын барилга байгууламжийн хүртээмж 2021 онд 61м², 2022 онд 62м², 2023 онд 63,5м², 2024 онд 65мкв байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 53 дугаар зарлигийн дагуу бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил авах ажлыг нийслэлийн хэмжээнд 2024 оны IV-VI, IX-XII саруудад зохион байгуулж 193,000 иргэн хамрагдсан бол сорилд хамрагдсан нийт иргэдийн 80 хувь нь А, В, С үнэлгээ авсан үзүүлэлттэй үнэлэгдсэн. 2024 онд Баянгол, Налайх дүүрэгт сорилын шинэ төв байгуулагдсан байгаа нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн гэж үзээд 100 хувьтай гэж үнэллээ.

ДҮГНЭЛТ:

Монгол улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд биеийн тамир, спортын чиглэлээр тусгагдсан зорилт, арга хэмжээний 2024 оны жилийн эцсийн үйл ажиллагааны хэрэгжилтийг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын дагуу “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2.1, 6.2.2-т заасан аргачлалын дагуу тооцож, зорилт, арга хэмжээний дундаж үнэлгээгээр бодлогын зорилго, зорилтын хэрэгжилтийг тус журмын 6.2.3 дахь заалтын дагуу шилжүүлэн тооцож 100 хувьтай буюу “үр дүнтэй” гэж үнэллээ.

ТАНИЛЦСАН:

НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

С.САРАНЦЭЦЭГ

ХЯНАСАН:

ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТ, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА

М.ЦОГЗОЛМАА

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

ХҮНИЙ НӨӨЦ ХАРИУЦСАН

МЭРГЭЖИЛТЭН

Б.ОЮУНТУЯА



Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын
 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн
 02/2024 дүгээр албан бичгийн
 дөрөвдүгээр хавсралт



НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗАР
 НИЙСЛЭЛИЙН ХӨГЖЛИЙН 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНД БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ЧИГЛЭЛЭЭР
 ТУССАН АРГА ХЭМЖЭЭНИЙ ЯВЦЫН ТАЙЛАН

2024 оны 12 дугаар сарын 13

Улаанбаатар хот

№	Бодлогын үндэслэл	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Үндсэн хэрэг жүүлэх байгууллага	Эх үүсвэр	Суурь түвшин 2022 он	Зорилтот түвшин, үр дүн (хөрөнгийн хэмжээ эх үүсвэр)			Хэрэгжилт	Хэрэг жил тийн хувь
						Зорилтот Түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв сая.төг	Төсвийн гүйцэтгэл сая.төг		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1.	АХ-3.5.4, МУХТЖҮЧ-3.5.3, ЗГҮАХ-ХАХТ-2.2.1.1., НХТЖҮЧ-3.5.3 НЗДҮАХ-2.2.1	Спортын клубүүдийг магадлан итгэмжлэлд хамруулах	НБТСГ	-	13	13	-	-	Спорт клубүүд магадлан итгэмжлэлд сайн дурын үндсэн дээр хамрагдах, магадлан итгэмжлэгдсэн клубүүдэд хичээллэж буй иргэд эрүүл мэндийн даатгалын сангаас урамшуулал авах эрх зүйн орчин 2019 оноос үйлчилж 2021 оноос түр зогссон. Спорт клубүүдийг магадлан итгэмжлэлд хамрагдах зөвшөөрлийг Засгийн газрын тохируулагч агентлаг Биеийн тамир, спортын улсын хорооноос олгодог байсан. Стандарт шаардлага хангасан орчинд магадлан итгэмжлэгдсэн сургалтын хөтөлбөрөөр мэргэжлийн багш дасгалжуулагч ажиллах, магадлан итгэмжлэгдсэн спорт клубүүдээр хичээллэх иргэд нийгмийн даатгалын сангаас урамшуулал авах эрх зүйн орчин бүрдсэний дараа нийслэл, дүүргийн Биеийн тамир, спортын хороод хамруулах ажлыг зохион байгуулна. Хэрэгжилт 70%	70%
									Нийслэлийн Биеийн тамир, спортын газраас 2024 оны жилийн эцсийн байдлаар нийтийг хамарсан 17 үйл ажиллагаа зохион байгуулж (сургуулийн	

2.		Нийтийг хамарсан биеийн тамирын томоохон арга хэмжээнүүдийг зохион байгуулан иргэдийн оролцоог нэмэгдүүлэх	НБТСГ	Нийслэлийн төсвөөс	44,130	450.196	1,092.9	Улсын төсвөөс 34,145.0	өмнөх боловсролын байгууллага, ерөнхий боловсролын сургуулийн багш нарын сургалт, аэробикийн сургалт, хөгжөөн дэмжигчдийн арга хэмжээ, цэцэрлэгийн уран хөдөлгөөнт гимнастик, софт, хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил, шүүгчдийн сургалт, “Улаанбаатар марафон-2024”, “Алхацгаая гүйцгээе” хөдөлгөөн, олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийн арга хэмжээ, “Даншиг наадам-хүрээ цам” наадам, Нүүдэлчин, Спорт явган аяллын шигшээ тэмцээн, Автомашингүй өдөр арга хэмжээ, Нийслэлийн Иргэдийн спортын XII наадам, ЕБС-ийн сурагчдын уран хөдөлгөөнт гимнастикийн тэмцээн) 1995 байгууллага, 450.200 иргэнийг хамруулсан. Хэрэгжилт 100%	100%
3.		Өвлийн спортын арга хэмжээг зохион байгуулж иргэдийн оролцоог нэмэгдүүлэх.	НБТСГ	Нийслэлийн төсвөөс	412,000	413,000	70.1	-	Өвлийн улиралд иргэдийн бие бялдрыг чийрэгжүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлэн 2024 оны жилийн эцсийн байдлаар 414,200 иргэнд үйлчилгээ үзүүлж ажилласан байна. Үүнд: Нийслэлийн 9 дүүрэгт өвлийн спортын нийтийг хамарсан 10 арга хэмжээ зохион байгуулж 25.909 иргэнийг хамруулсан. Улаанбаатар хотын аварга шалгаруулах уралдаан өвлийн спортын 7 төрлөөр зохион байгуулж 693 тамирчдыг хамруулсан. Дүүргүүдийн Засаг даргын дэргэдэх Өсвөрийн шигшээ багт өвлийн спортын 3 төрөл (хоккей, тэшүүр, шорт-трейк)-ийн төрлөөр 95 хүүхэд, багачууд секц, дугуйланд хамрагдсан. Монголын Тэшүүр, Хоккейн холбооны дэргэдэх бүртгэлтэй дугуйлан, секцэд 175 хүүхэд спортын 3 (тэшүүр, хоккей, уран гулгалт) төрөлд хамрагдаж байна. Хан-Уул, Чингэлтэй дүүрэгт байрлах битүү дээвэртэй мөсөн гулгуурын талбайд 2024 оны 01 дүгээр сарын 02-ноос 12 дугаар	100%

									сарын 02-ны хооронд 129.054 иргэн үйлчлүүлсэн байна. Сүхбаатар, Баянзүрх, Багануур дүүрэг дэх Хандгайт, Скай ресорт, Галуут тур, Улаанбаатар цанын баазуудад 153.000 иргэн үйлчлүүлсэн. Орон сууц, гэр хорооллын 22 байршилд мөсөн гулгуурын талбай байгуулагдаж 105.544 иргэнд үйлчилгээ үзүүлсэн байна. Хэрэгжилт 100%	
4.	МУХТЖҮЧ-3.5.3 НХТЖҮЧ-3.5.3 НЗДҮАХ-2.2.1	Монголын оюутны спортын их наадмыг зохион байгуулах.	НБТСГ	Нийслэлийн төсөв	-	100	30.0	-	Монгол Улсын Засгийн газрын 2018 оны "Улсын хэмжээний спортын наадам зохион байгуулах тухай" 183 дугаар тогтоолын дагуу 2024 онд оюутны спортын их наадмыг спортын 10 төрөл (волейбол, гандбол, жүдо бөх, сагсан бөмбөг 5x5, таеквондо, футзал, чирлидинг, чөлөөт бөх, шатар, ширээний теннис) -өөр 2024 оны 04 дүгээр сарын 16-наас 26-ны өдрүүдэд Засгийн газрын тохируулагч агентлаг – Биеийн тамир, спортын улсын хороо хариуцан зохион байгуулж 2000 орчим тамирчин 533 багц медалийн төлөө өрсөлдсөн. Засгийн газрын тохируулагч агентлаг – Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2024 оны А/65 дугаар тушаалаар "Монголын оюутны спортын VI наадмын нэгдсэн заавар"-ыг бүрэлдэхүүн сургуулийн болон шигшээ тэмцээн гэсэн 2 үе шаттай баталсан. Наадам зохион байгуулах бэлтгэл ажлын төлөвлөгөөнд тусгагдсан нийслэл хариуцан гүйцэтгэх 2 чиглэлийн 5 ажлыг бие даан болон холбогдох байгууллагуудтай хамтран гүйцэтгэсэн. Спортын 10 төрөлд 40 орчим их дээд сургуулийн 9000 орчим оюутан хамруулсан. Хэрэгжилт 100%	100%
									Налайх, Багахангай, Баярзүрх дүүргийн спорт цогцолборыг барих ажил 88 хувь (Баянзүрх-85%, Багахангай-80%, Сүхбаатар-40%)-тай үргэлжилж байна. Үүнд:	100%

5.	АХ-3.5.5 НХТЖҮЧ-3.5.2 НЗДҮАХ-2.2.3	Баянзүрх, Сүхбаатар, Багахангай дүүргийн спорт цогцолборын барилга угсралтын ажлыг үргэлжлүүлэх.	НБТСГ	Улсын төсөв	55	70	3,680.1	-	<p>Баянзүрх дүүргийн спортын ордны бүтээн байгуулалтын ажилд 2024 онд 2.58 тэрбум төгрөг тусгагдсанаас үерийн далангийн ажил 70 хувьтай хийгдсэн барилгын нийт ажлын гүйцэтгэл 85 хувьтай хэрэгжиж байна. Багахангай дүүргийн Засаг даргын 2019 оны А/193 дугаар захирамжаар тус дүүргийн 2-р хороонд спорт цогцолбор барих зориулалтаар 1000 м2 газар олгогдсон. Тус спорт цогцолборын барилгын ажлын гүйцэтгэгчээр 2022 онд “Алтан шар говь” ХХК шалгарч улсын төсвөөс 2022 онд 500.0 сая, 2023 онд 815.6 сая, 2024 онд 1.100.0 сая төгрөгийн санхүүжилтээр барилгын ажлын 80 хувийг гүйцэтгэсэн. Сүхбаатар дүүргийн спорт цогцолбор 40 хувьтай байна. Нийслэлийн Засаг даргын 2010 оны 819-р захирамжаар 0.18 га газар олгогдсон. Эрүүл мэнд, спортын яамнаас 2015 онд зохион байгуулсан тендерт “Герийн ресурс” ХХК шалгарч улсын төсвөөс 5,200.0 сая төгрөгийн санхүүжилтийг авч тухайн спорт цогцолборын нийт ажлын 40 хувийг гүйцэтгэсэн. Энэхүү спорт цогцолбор нь нийт 9,936.8 сая төгрөгийн өртгөөр баригдана. 2023, 2024 онд төсөв тусгагдаагүй.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт 100%</p>	
6.	АХ-3.5.5 МУХТЖҮЧ-3.5.2 ЗГҮАХ-ХАХТ- 2.2.3 НХХЗ-3.12.1, 3.12.2 НХТЖҮЧ-3.5.2, НЗДҮАХ-2.2.3	Ерөнхий боловсролын сургуулиудын биеийн тамир, спортын талбайг иж бүрэн тохижуулах.	НБГ, НБТСГ	-	2	2	-	-	<p>2024 онд Баянгол дүүргийн 22-р сургуулийн биеийн тамирын талбайг бүрэн шинэчлэх ажлыг 379.4 сая төгрөгийг нийслэлийн төсвөөс зарцуулж “Даг Жан пропертийс” ХХК хийж гүйцэтгэсэн бол Сонгинохайрхан дүүргийн 169-р сургуулийг биеийн тамирын гадна талбайг шинээр барьж байгуулсан. Мөн Монголын Хөл бөмбөгийн холбооноос 2024 онд Баянгол дүүргийн Оюуны ундраа цогцолбор сургуулийн гадна талбайг үерийн далан байгуулах ажлыг хийсний дараа хөл бөмбөгийн</p>	100%

									стандарт хиймэл зүлгээр шинэчилж тохижуулахаар хүлээгдэж байна. Хөл бөмбөгийн талбайн стандарт хиймэл зүлгийг захиалж ирүүлээд байна. Хэрэгжилт 100%	
7.	АХ-3.5.5, 9.1.18, МУХТЖҮЧ-3.5.2 ЗГҮАХ-2.2.3 НХХЗ-3.12.1, 3.12.2 НХТЖҮЧ-3.5.2, НЗДҮАХ-2.2.3.	Багийн спортоор хичээллэх хүүхэд, багачуудын оролцоог нэмэгдүүлэх.	НБТСГ	Улсын төсөв	141,730	145,250	362.4	138.2	Багийн спортын төрлөөр дамжуулан өсвөр үеийн хүүхэд, багачуудын бие бялдрыг чийрэгжүүлэх, хамтач үзэл санааг төлөвшүүлэх зорилгоор 2024 онд “Улаанбаатар лиг” сагсан бөмбөг, волейбол, “Улаанбаатар цом”, Багийн спортын төрлөөр дамжуулан өсвөр үеийн хүүхэд, багачуудын бие бялдрыг чийрэгжүүлэх, хамтач үзэл санааг төлөвшүүлэх зорилгоор 2024 онд “Улаанбаатар лиг” сагсан бөмбөг, волейбол, “Улаанбаатар цом”, “Мөрөөдлийн гоол” хөлбөмбөгийн тэмцээнүүдийг зохион байгуулж 158,746 тамирчин, иргэд, хүүхэд, багачуудыг хамруулсан. “Улаанбаатар лиг” сагсан бөмбөгийн тэмцээнийг бага, дунд, ахлах насны ангиллаар 5 үе шаттай амжилттай зохион байгуулж 9 дүүргийн ерөнхий боловсролын 192 сургуулийн охид, хөвгүүдийн 8208 багийн 90550 мянга гаруй сурагч оролцсон. “Улаанбаатар лиг” волейболын тэмцээнийг 2 насны ангиллаар 3 үе шаттай зохион байгуулж 9 дүүргийн ерөнхий боловсролын 141 сургуулийн 520 багийн 67098 сурагчид оролцсон. Нийслэлийн иргэдийн дунд “Улаанбаатар цом” хөл бөмбөгийн тэмцээнийг Монголын хөл бөмбөгийн холбоотой хамтран зохион байгуулж 7 дүүргийн 98 тамирчид оролцсон. Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд “Мөрөөдлийн гоол” хөлбөмбөгийн тэмцээнийг Монголын Хөлбөмбөгийн холбоотой хамтран зохион байгуулж 66 багийн 1000 гаруй хүүхэд, багачуудыг тус тус. Хэрэгжилт 100%	100%

8.	X-3.5.5, 9.1.18, МУХТЖҮЧ-3.5.2 ЗГҮАХ-2.2.3 НХХЗ-3.12.1, 3.12.2 НХТЖҮЧ-3.5.2, НЗДҮАХ-2.2.3.	Нийслэл, дүүргийн аварга шалгаруулах тэмцээнүүдийг зохион байгуулах.	НБТСГ	Улсын төсөв	217 уралдаан тэмцээнд 39,031 тамирчид	267 уралдаан тэмцээнд 35,772 тамирчид	422.4	Улсын төсвөөс 15.9 Нийс лэлийн төсвөөс 38.4	Улаанбаатар хотын аварга шалгаруулах тэмцээнийг спортын 23 төрлөөр зохион байгуулж 301 байгууллагын 7888 тамирчид оролцсон. Мөн нийслэл, дүүргийн аварга шалгаруулах тэмцээнийг 176 удаа зохион байгуулж 11422 байгууллагын 197275 тамирчдыг хамруулсан. Хэрэгжилт 100%	100%
9.	АХ-3.5.5, МУХТЖҮЧ-3.5.2 ЗГҮАХ-2.2.3 НХХЗ-3.12.1, 3.12.2 НХТЖҮЧ-3.5.2, НЗДҮАХ-2.2.2.5	Дүүргийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийн байнгын дасгал сургалт хийх нөхцөлийг хангах.	НБТСГ	Улсын төсвөөс	25	26	16.0	-	Өндөр зэрэгтэй тамирчдын залгамж халааг тасралтгүй бэлтгэх, биеийн тамир, спортын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж дүүргийн Засаг даргын дэргэдэх Өсвөрийн шигшээ багийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулж спортын 28 төрөлд 109 багт 109 дасгалжуулагчтай 3525 тамирчдыг бэлтгэл сургуулилтад хамруулж байна. Өсвөрийн шигшээ багийн тамирчид 2024 оны жилийн эцсийн байдлаар тив, дэлхий, олон улс, улс, нийслэл, нэрэмжит 521 удаагийн тэмцээнд оролцож 2707 медаль авсан амжилт үзүүлсэн байна. Баянзүрх, Сүхбаатар, Сонгинохайрхан, Хан-Уул, Чингэлтэй, Багануур, Налайх, Налайх дүүрэг өсвөрийн шигшээ багийн үйл ажиллагааг дэмжиж 288.230.241 (хоёр зуун наян найман сая хоёр зучин мянган хоёр зуун дөчин нэгэн мянган) төгрөгийг зарцуулсан байна. Хэрэгжилт 100%	100%
Хэсгийн дундаж									97%	

ТАНИЛЦСАН:
НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР СПОРТЫН
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
ХЯНАСАН:
ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТ, САНХҮҮГИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА
ТАЙЛАН НЭГТГЭСЭН:
ЭРХ ЗҮЙ, ТОГТООЛ ШИЙДВЭР
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН



С.САРАНЦЭЦЭГ

М.ЦОГЗОЛМАА

Н.СҮНЖИДМАА

НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗАР

ИЛТГЭХ ХУУДАС

2024 оны 12 дугаар сарын 13

Улаанбаатар хот

НИЙСЛЭЛИЙН ХӨГЖЛИЙН 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНД БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН
ЧИГЛЭЛЭЭР ТУССАН АЖЛЫН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТЭД
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТУХАЙ

ЗОРИЛГО:

Нийслэлийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд биеийн тамир, спортын чиглэлээр тусгагдсан арга хэмжээний төлөвлөгөөний явцы тайланг зорилт, хүрэх түвшин, шалгуур үзүүлэлттэй харьцуулан тооцож, үр дүнг үнэлэн, дүгнэлт өгч, зөвлөмж боловсруулж, удирдлагыг үнэн бодит мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, хариуцлагыг сайжруулахад хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго оршино.

Нийслэлийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд биеийн тамир, спортын чиглэлээр тусгагдсан зорилт, арга хэмжээний 2024 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн ажлын үр дүнг <https://erp.ulaanbaatar.mn/> системээр хяналт-шинжилгээ, үнэлгээ цэсэнд байршуулж хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.


АРГА ЗҮЙ:

Нийслэлийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд биеийн тамир, спортын чиглэлээр тусгагдсан 10 арга хэмжээний явцын тайланг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын дагуу “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ийн 6.2.1, 6.2.2-т заасан аргачлалын дагуу тооцож, зорилт, арга хэмжээний дундаж үнэлгээгээр бодлогын зорилго, зорилтын хэрэгжилтийг тус журмын 6.2.3 дахь заалтын дагуу шилжүүлэн тооцсон.

ДҮГНЭЛТ:

Нийслэлийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд биеийн тамир, спортын чиглэлээр тусгагдсан зорилт, арга хэмжээний 2024 оны жилийн эцсийн тайланг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын дагуу “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2.1, 6.2.2-т заасан аргачлалын дагуу тооцож, зорилт, арга хэмжээний дундаж үнэлгээгээр бодлогын зорилго, зорилтын хэрэгжилтийг тус журмын 6.2.3 дахь заалтын дагуу шилжүүлэн тооцож 96.67 хувьтай буюу “тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэллээ.


ТАНИЛЦСАН:

НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ  С.САРАНЦЭЦЭГ

ХЯНАСАН:

ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТ, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА  М.ЦОГЗОЛМАА

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

ХҮНИЙ НӨӨЦ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН 

Б.ОЮУНТУЯА

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын
 2024 оны 12 дугаар сарын 16 ны өдрийн
 02/26/2024 дүгээр албан бичгийн тавдугаар хавсралт



"НИЙСЛЭЛИЙГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ" ДУНД ХУГАЦААНЫ ТӨЛӨВЛӨЛТИЙН БАРИМТ БИЧГИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН 2021-2024 ОНЫ ХЭРЭГЖИЛТ

2024 оны 12 дугаар сарын 16

Улаанбаатар хот

д/д	№	Бодлогын зорилго, зорилт арга хэмжээ	Төсөв /сая төг/		Үр дүнгийн шалгуур үзүүлэлт	Суурь түвшин		Зорилтот түвшин		Хэрэгжилт	Хүрсэн буюу гүйцэтгэлийн хувь	Тайлбар (Хүрээгүй бол шалтгаан нөхцөлийн тайлбар)	Хариуцах байгууллага
			Төсөвлөсөн	Гүйцэтгэл		Он	Түвшин	Он	Түвшин				
Зорилт 3.5. Биеийн тамир, спортоор хичээллэх орчин нөхцөлийг сайжруулж, иргэдэд үзүүлэх үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.													
1.	3.5.1	Нийслэлийн хүн амд үзүүлэх биеийн тамир, спортын үйлчилгээний чанар сайжирсан байна.	150,9	-	Биеийн тамирын арга зүйч	2019	0	2024	Биеийн тамирын 17 арга зүйчтэй болсон байна.	Анхан шатны нэгжид биеийн тамир, спортын үйлчилгээг түргэн шуурхай, хүртээмжтэй хүргэх зорилгоор дүүргийн хороодод орон тооны биеийн тамирын арга зүйч ажиллуулах саналыг Биеийн тамир, спортын улсын хороонд 2021 оны 2/73 албан тоотой, 2022 онд Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс, Хууль, эрх зүйн хэлтэст тус тус 3/235 албан тоотой, 2023 онд Олимп, нийтийн биеийн тамир, спортын үндэсний хороонд 3/225 албан тоотой, Биеийн	90	Биеийн тамир, спортын тухай хуульд өөрчлөлт оруулж орон тооны арга зүйч ажиллуулах саналыг 2021,2022, 2023 онуудад удаа дараалан холбогдох байгууллагуудад хүргүүлж ажилласнаар 2024 онд тухайн	НБТСГ

										тамир, спортын улсын хороонд 3/225 албан тоотой тус тус хүргүүлсэн. Дээрх санал Биеийн тамир, спортын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгагдан Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргэгдсэн. “Биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулга 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн Улсын Их хурлын хаврын чуулганаар “Сум, хороодод орон тооны биеийн тамирын арга зүйч ажиллаж биеийн тамир, спортын хуулийг хэрэгжүүлж орон нутгийн төсвөөс дэмжлэг үзүүлнэ” батлагдсан. 2025 оноос эхлэн хэрэгжиж эхэлнэ. Үр дүн: Хороодод орон тооны арга зүйч ажиллуулах заалт “Биеийн тамир, спортын тухай хууль”-д заалт болон тусгагдаж нийслэлийн хэмжээнд хэрэгжүүлэх боломж бүрдсэн.		хуулийн шинэчилсэн найруулгаар батлагдаж 2025 оноос хэрэгжиж эхлэх боломж бүрдсэн. Хуульд нэмэлт өөрчлөлт оруулах нь манай байгууллагын чиг үүрэг биш болно.	
2.			-	-		2019	11	2024	23	Спорт клубүүдийг магадлан итгэмжлэлд хамрагдах зөвшөөрлийг Засгийн газрын тохируулагч агентлаг Биеийн тамир, спортын улсын хорооноос олгодог. Нийслэл, дүүргийн	90	Магадлан итгэмжлэлд сайн дурын үндсэн дээр хамрагдах хуулийн заалттай.	НБТСГ

					Магадлан итгэмжлэгдсэн спорт клуб				<p>Биеийн тамир, спортын хороод спорт клубүүдийг сайн дурын үндсэн дээр магадлан итгэмжлэлд хамрагдах чиглэлээр арга зүйн зөвлөгөө өгч магадлан итгэмжлэлд ороход бэлэн болсон материалуудыг Биеийн тамир, спортын улсын хороонд хүргүүлж ажилладаг. Энэ хүрээнд 2021 онд 2 спорт клуб магадлан итгэмжлэгдэж нийт 13 спорт клуб болсон. 2022 онд Налайх дүүргийн “Налайх спиннинг” клуб, Сонгинохайрхан дүүргийн “Бумба од” фитнес клубийн материалыг Биеийн тамир, спортын улсын хороонд хүргүүлсэн. 2023 онд 6 спорт клубт арга зүйн зөвлөгөө өгч магадлан итгэмжлэлд орох материалыг бэлтгэсэн боловч Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2019 оны А/178, А/144 дүгээр тушаалаар батлагдсан Спортын клубийн магадлан итгэмжлэх журмын холбогдох заалтуудад нэмэлт өөрчлөлт оруулах шаардлага тулгарсан тул түр хүлээгдсэн. 2024 онд Биеийн тамир, спортын тухай хууль шинэчлэгдсэнтэй</p>	<p>Магадлан итгэмжлэх ажлыг Биеийн тамир, спортын улсын хороо хийдэг. Нийслэл, дүүргийн Биеийн тамир спортын хороод зөвлөн туслах үйлчилгээ үзүүлдэг.</p>	
--	--	--	--	--	-----------------------------------	--	--	--	---	---	--

									<p>холбогдуулан Биеийн тамир, спортын улсын хорооноос “Спорт клубийн магадлан итгэмжлэх журмыг шинэчилж байгаа тул магадлан итгэмжлэх спорт клубын материалыг хүлээн аваагүй бөгөөд энэ чиглэлээр зөвлөн туслах ажлыг хийж байна.</p> <p>Үр дүн: Стандарт шаардлага хангасан орчинд магадлан итгэмжлэгдсэн сургалтын хөтөлбөрөөр мэргэжлийн багш дасгалжуулагч ажиллаж иргэдэд чанартай үйлчилгээ үзүүлэх чиглэлээр 2020 оноос хойш 2 спорт клуб магадлан итгэмжлэгдэж нийт 13 спорт клуб болоод байна. Энэ ажлыг үргэлжлүүлж 2022 онд 2 спорт клуб, 2023 онд 6 спорт клубийг магадлан итгэмжлэлд оруулах материал бэлтгэгдсэн. 2024 онд магадлан итгэмжлэх чиглэлээр зөвлөн туслах ажлыг хийж байна.</p>				
3.			-	-		2019	53	2024	58	2021 онд Коронавируст халдвар (Ковид-19) цар тахлын тархалттай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 53 дугаар зарлигийн дагуу хүн амын бие бялдрын хөгжилт, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил авах ажил	100	Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 53 дугаар зарлигийн дагуу хүн амын бие бялдрын хөгжилт,	НБТСГ

					Иргэдийн бие бялдрын хөгжлийн суурь үзүүлэлт					<p>зохион байгуулагдаагүй. 2022 онд нийслэлийн хэмжээнд 87,356 иргэн хамрагдсан бөгөөд нийт хамрагдсан иргэдийн 60 хувь нь А, В, С үнэлгээ авсан байна.</p> <p>2023 онд 175,500 иргэн хамрагдсанаас 82 хувь нь А, В, С үнэлгээ авсан байна.</p> <p>Бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил авах ажлыг нийслэлийн хэмжээнд 2024 оны IV-VI, IX-XII саруудад зохион байгуулж 193,000 иргэн хамрагдсан бол сорилд хамрагдсан нийт иргэдийн 80 хувь нь А, В, С үнэлгээ авсан үзүүлэлттэй үнэлэгдсэн.</p> <p>Үр дүн: Бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилд 2019 онд нийт хамрагдсан иргэдээс 53 хувь нь А, В, С үнэлгээг авч байсан бол 2024 онд нийт хамрагдсан иргэдээс 80 хувь нь А, В, С үнэлгээ авсан.</p>	Чийрэгжилтийн түвшин тогтоох сорил авах ажлыг жил бүр зохион байгуулдаг.	
4.	3.5.2	Дүүрэг, хороод болон шинэ дагуул хот, шинэ дэд төвүүдэд биеийн тамир, спортын	-	-	Төрөлжсөн спортын талбай	2019	94	2024	104	100	Биеийн тамир, спортын зориулалтын талбай 2019 оны суурь үзүүлэлт 101 байсан бол 2022 онд 3, 2023 онд 36,	НБТСГ

		барилга байгууламжийг норм, стандартын дагуу барьж байгуулсан байна.								дүүргийн 8 дугаар хороонд хөл бөмбөгийн талбай бүхий техникийн төв, 34, 52, 2-р сургуулиудын гадна талбайг хөл бөмбөгийн хиймэл зүлэг болон бусад тоноглолоор тохижуулсан) 105 болсон. 2023 онд 36 талбай (Нийслэлийн Хот тохижилтын газар хариуцан 3х3 сагсан бөмбөгийн 34 талбайг ашиглалтад оруулсан бол 57, 67-р сургуулийн спорт талбайг шинэчлэн тохижуулсан.)-аар нэмэгдэж 141 болсон. 2024 онд 62 (Нийслэлийн Хот тохижилтын газар хариуцан ажиллаж 3х3 сагсан бөмбөгийн 40 талбайг, Нийслэлийн Захирагчийн ажлын албанаас 20 байршилд байгуулсан. Мөн 22, 169-р сургуулийг биеийн тамирын гадна талбайг байгуулан ашиглалтад оруулсан)-аар 203 болсон. Үр дүн: Биеийн тамир, спортын зориулалтын талбай 2019 оны суурь үзүүлэлт 101 байсан бол 2022 онд 3, 2023 онд 36, 2024 онд 62-оор тус тус нэмэгдэж 203 болсон.		2024 онд 62-оор тус тус нэмэгдэж 203 болсон.	
5.			УТ 4,121	УТ 4,121		2019	60	2024	64	Нийслэлийн хэмжээнд 1000 хүнд оногдох спортын барилга байгууламжийн хүртээмж 2021 онд 61м2,	100	Спортын барилга байгууламжийн хүртээмжийг	НБТСГ

					Спортын барилга байгууламжийн хүртээмж			2022 онд 62м2, 2023 онд 63,5м2, 2024 онд урьдчилсан байдлаар 65мкв-д хүрсэн үр дүнтэй байна. Үүнд: 2021 онд Чингэлтэй дүүргийн спорт цогцолбор, Хан-Уул дүүрэгт битүү дээвэртэй өвлийн спортын ордон, Баянгол дүүргийн 4-р сургуулийн спорт заал, Багануур дүүрэгт спорт заал, Баянгол дүүргийн 20 дугаар сургуульд усан бассейн ашиглалтад орсон бол 2022 онд Баянгол дүүрэгт 650 хүний суудалтай спорт цогцолбор, "Gan sports center", "UG Arena" спорт цогцолбор, Баянзүрх дүүрэгт Чухаг спорт төв тус тус ашиглалтад орсон. 2023 онд Хан-Уул дүүрэгт Наадам спорт клуб, В3 NBA спорт заал, Emart спорт заал, Сүхбаатар дүүрэгт Shine sport center спорт заал, Сонгинохайрхан дүүрэгт "ОБ" спорт заал, Толгойт хөгжлийн төвийн спорт заал, "City" спорт заал ашиглалтад орсон. 2024 онд Налайх дүүргийн спорт цогцолборын барилгын ажлыг "Бүрд констракшн" улсын төсвөөс 15.0 тэрбум төгрөгийн санхүүжилт авч 2012-2024 онд 100% гүйцэтгэсэн. Мөн ерөнхий боловсролын 7	"Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм, БНБД 30-01-04-ийн дагуу спортын заалны шалны талбайн хэмээг 1000 хүнд харьцуулан тооцдог.	
--	--	--	--	--	---	--	--	--	---	--

									<p>сургууль (Сонгинохайрхан дүүргийн 12, 169, Хан-Уул дүүргийн 10, Баянзүрх дүүргийн 14, Чингэлтэй дүүргийн 5, Баянгол дүүргийн бага сургууль цэцэрлэгийн цогцолбор, Налайх дүүргийн голомт цогцолбор) спортын заалтай баригдсан байна. Улсын төсвөөр баригдаж байгаа Баянзүрх дүүргийн спорт цогцолбор 85 хувьтай, Сүхбаатар дүүргийн спорт цогцолбор 40 хувьтай, Нийслэлийн Спорт цогцолбор 50 хувьтай, Багахангай дүүргийн спорт цогцолбор 80 хувьтай, Хан-Уул дүүргийн Оюуны спортын ордон 80 хувьтай баригдаж байгаа бол Азийн хөгжлийн банкны 60 хувь, нийслэлийн төсвийн 40 хувийн хөрөнгө оруулалтаар баригдаж байгаа Баянхошуу дэд төвийн спорт цогцолбор 70 хувьтай үргэлжилж байна.</p> <p>Үр дүн: Биеийн тамир, спортын барилга байгууламжийн хүртээмж 2019 онд 60 мкв байсан бол 2021-2024 онд 5мкв-аар нэмэгдүүлж 65 мкв-д хүргэсэн байна.</p>		
--	--	--	--	--	--	--	--	--	---	--	--

6	3.5.3	Нийслэлийн иргэдийн дунд биеийн тамир, спортын арга хэмжээнүүдийг зохион байгуулснаар оролцоог нэмэгдүүлсэн байна.	610,0	УТ 701.5 НТ 1,018 ОНТ 565,7	Нийт хүн амд биеийн тамир, спортын арга хэмжээнд хамрагдсан иргэн	2019	725,196	2024	830,080	Коронавируст халдвар (Ковид-19)-ын тархалтаас шалтгаалан Нийслэлийн Биеийн тамир, спортын газраас 2021 онд биеийн тамирын 6 арга хэмжээ, 13 удаагийн цахим сургалтыг зохион байгуулж 89,449 иргэнд хүргэж ажилласан бол нийслэл дүүргийн хэмжээнд 340 арга хэмжээг цахим болон практик хэлбэрээр зохион байгуулж 2876 байгууллагын 635.486 иргэнийг хамруулсан. 2022 онд нийслэл, дүүргийн хэмжээнд биеийн тамирын 340 арга хэмжээнд 1,170,073 иргэн хамруулсан. Үүнээс: Нийслэлийн Биеийн тамир, спортын газраас 14 арга хэмжээг зохион байгуулж 9407 байгууллагын 423,511 иргэнийг хамруулсан. 2023 онд нийслэл, дүүргийн хэмжээнд 368 арга хэмжээнд 9930 байгууллагын 873,313 иргэдийг хамруулсан. Үүнээс: Нийслэлийн Биеийн тамир, спортын газраас нийтийг хамарсан 24 арга хэмжээ зохион байгуулж 2481 байгууллагын 416,000 иргэнийг хамруулсан. Нийслэл, дүүргүүдийн хэмжээнд 2024 онд 345 арга хэмжээ зохион байгуулж 6413 байгууллагын 888500	100	2024 оны хүрэх түвшинд бүрэн хүрсэн.	НБТСГ
---	-------	--	-------	--	---	------	---------	------	---------	---	-----	--------------------------------------	-------

									иргэдийг хамруулсан. Үүнээс: Нийслэлийн Биеийн тамир, спортын газраас 2024 онд 17 үйл ажиллагаа зохион байгуулж (сургуулийн өмнөх боловсролын байгууллага, ерөнхий боловсролын сургуулийн багш нарын сургалт, аэробикийн сургалт, хөгжөөн дэмжигчдийн арга хэмжээ, цэцэрлэгийн уран хөдөлгөөнт гимнастик, софт, хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил, шүүгчдийн сургалт, “Улаанбаатар марафон-2024”, “Алхацгаая гүйцгээе” хөдөлгөөн, олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийн арга хэмжээ, “Даншиг наадам-хүрээ цам” наадам, Нүүдэлчин, Спорт явган аяллын шигшээ тэмцээн, Автомашингүй өдөр арга хэмжээ, Нийслэлийн Иргэдийн спортын XII наадам, ЕБС-ийн сурагчдын уран хөдөлгөөнт гимнастикийн тэмцээн) 1995 байгууллага, 450.200 иргэнийг хамруулсан. Үр дүн: Нийслэлийн иргэдийн дунд нийтийг хамарсан арга хэмжээ, ажил үйлчилгээнд 2019 онд 756,451 иргэдийг хамруулж		
--	--	--	--	--	--	--	--	--	---	--	--

										байсан бол 2024 онд нийслэлийн хэмжээнд 888500 иргэдийг хамруулж хамрагдагчдын тоог 132049 хүнээр нэмэгдүүлсэн байна.			
7	3.5.4	Нийслэлд спортын төрлүүдийг хөгжүүлж, тамирчдын залгамж халааг тасралтгүй бэлтгэдэг болсон байна.	УТ 146.8 НТ 270.0	УТ 51.4 НТ 170.6	Тэмцээнд оролцсон тамирчид	2019	152,096	2024	152,340	Спортын тэмцээн уралдааныг үндэсний спорт, орчин үеийн спортын төрөл болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төрлөөр өсвөр үе, залуучууд, насанд хүрэгчдийн насны ангиллаар 2021 онд нийт 23 удаа зохион байгуулж 518 тамирчдыг, 2022 онд 19 удаа зохион байгуулж 804 тамирчдыг, 2023 онд 38 төрлөөр зохион байгуулж 673 тамирчдыг оролцсон. Спортын тэмцээн уралдааныг үндэсний спорт, орчин үеийн спортын төрөл болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төрлөөр өсвөр үе, залуучууд, насанд хүрэгчдийн насны ангиллаар 2024 онд 29 төрлөөр зохион байгуулж 601 тамирчдыг оролцсон. Үүнд 27 спортын холбоотой ажил гүйцэтгэх, хамтран ажиллах гэрээ байгуулж Улаанбаатар хотын аварга шалгаруулах тэмцээнийг	100	2024 оны хүрэх түвшинд бүрэн хүрсэн.	НБТСГ

									спортын 23 төрлөөр, даншиг наадмыг үндэсний спортын 3 төрлөөр, нүүдэлчин дэлхийн соёлын фестивалийг зохион байгуулж 301 байгууллагын 7888 тамирчид оролцсон бол багийн төрлөөр “Улаанбаатар лиг” сагсан бөмбөг, волейбол, “Улаанбаатар цом”, “Мөрөөдлийн гоол” хөл бөмбөгийн тэмцээнүүдийг зохион байгуулж 158,746 тамирчин, иргэд, хүүхэд, багачууд оролцсон. Үр дүн: Спортын тэмцээнд 2019 онд 152096 хүүхэд, багачууд, тамирчид хамрагдаж байсан бол 2024 онд 14538 тамирчнаар нэмэгдэж хүрэх түвшинд бүрэн хүрч 166634 тамирчид оролцсон.				
8.			-	-	Өсвөрийн шигшээ багуудын спортын төрөл	2019	22	2024	24	Биеийн тамир, спортын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж өндөр зэрэгтэй тамирчдын залгамж халааг тасралтгүй бэлтгэхэд дэмжлэг үзүүлж ажилласны үр дүнд дүүргүүдийн Засаг дарга нарын дэргэдэх спортын шигшээ багийг 2021 онд спортын 24 төрлөөр 82 дасгалжуулагч, 1814 тамирчин хамрагдсан. 2022 онд спортын 3 төрөл (крикет, хоккей, усан спорт)-өөр нэмэгдүүлж 25 төрлөөр 65 багт 101 дасгалжуулагч,	100	Өсвөрийн шигшээ багуудад Дүүргүүдийн Засаг даргын нөөцөөс тодорхой хэмжээний санхүүжилт авч үйл ажиллагаагаа явуулдаг.	НБТСГ

									<p>2856 тамирчин хамрагдсан. 2023 онд 9 дүүргийн Засаг даргын дэргэдэх өсвөр үеийн шигшээ багийг спортын 28 төрлөөр 105 дасгалжуулагч 2944 тамирчдын бүрэлдэхүүнтэйгээр бэлтгэл, сургуулилт, дасгалжуулалтад хамруулсан.</p> <p>2024 онд дүүргүүдийн Засаг дарга нарын дэргэдэх өсвөрийн шигшээ багийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулж спортын 28 төрөлд 109 багт 109 дасгалжуулагчтай 3525 тамирчдыг бэлтгэл сургуулилтад хамруулж байна. Өсвөрийн шигшээ багийн тамирчид 2024 онд тив, дэлхий, олон улс, улс, нийслэл, нэрэмжит 521 удаагийн тэмцээнд оролцож 2707 медаль авсан амжилт үзүүлсэн бол Баянзүрх, Сүхбаатар, Сонгинохайрхан, Хан-Уул, Чингэлтэй, Багануур, Налайх, Налайх дүүрэг өсвөрийн шигшээ багийн үйл ажиллагааг дэмжиж 288.2 сая төгрөгийг зарцуулсан байна.</p> <p>Үр дүн: Тамирчдын залгамж халааг тасралтгүй бэлтгэх зорилгоор өсвөрийн шигшээ багийг 2020 онд 22 спортын төрлөөр байгуулж</p>		
--	--	--	--	--	--	--	--	--	---	--	--

										сургалт дасгалжуулалт явуулж байсан бол 2024 онд спортын 28 төрөл болгон өргөжүүлж суурь түвшнээс 6 төрлөөр нэмэгдүүлж бэлтгэл сургуулилт, дасгалжуулалтад хамруулж байна.			
9.	3.5.5	Нийслэл Улаанбаатар хотноо олон улсын спортын наадмыг зохион байгуулж дэлхийд сурталчлан таниулах ажлыг шат дараатай зохион байгуулсан байна.	УТ, НТ, бусад 18,000	УТ 10,600 НТ 6,800	Улаанбаатар хотноо зохион байгуулж буй Олон улсын спортын наадам	2019	0	2024	1	“Улаанбаатар -2023” Зүүн Азийн Залуучуудын наадмыг эх орондоо анх удаа 11 спортын 12 төрлөөр 2023 оны 08 дугаар сарын 16-наас 23-ны өдрүүдэд Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотод зохион байгууллаа. Тус наадмын бэлтгэл ажлын 30%-ийг 2021 онд, 70 хувийг 2022 онд, 2023 онд 100% хангаж ажилласан. Зүүн Азийн олимпын хороо нь есөн үндэсний олимпын хороог өөртөө нэгтгэдэг бөгөөд энэ удаагийн наадамд долоон үндэсний олимпын хорооны 880 тамирчин 8 өдрийн турш ур чадвар, авхаалж самбаа, хурд хүчээ сорин өрсөлдсөнөөс БНХАУ-ын баг, тамирчид 38 алт, 32 мөнгө, 19 хүрэл медаль авч багийн дүнгээр тэргүүлсэн бол Япон улс 22 алт, 7 мөнгө, 13 хүрэл, БНСУ 11 алт, 21 мөнгө, 24 хүрэл, Хятадын Тайвань 11 алт, 10 мөнгө, 21 хүрэл, Монгол улс 3 алт, 13 мөнгө, 28 хүрэл,	100	“Улаанбаатар 2023” Зүүн Азийн Залуучуудын наадмыг эх зохион байгуулах хорооноос төсвийг албан ёсоор тайлагнах үүрэгтэй.	НБТСГ

									Хятадын Хонконг 3 алт, 5 мөнгө, 12 хүрэл авсан амжилт үзүүлсэн байна. "Улаанбаатар-2023" Зүүн Азийн Залуучуудын наадмын зохион байгуулалтын бэлтгэл ажлыг спорт, ёслолын ажиллагаа, наадмын байгууламжууд, байр, сууц, ажиллах хүч, хангамж, тээвэр, мэдээлэл технологи, хэвлэл мэдээлэл, олон улсын харилцаа, протокол, баталгаажилт, бүртгэл, аюулгүй байдал, олон нийттэй харилцах, маркетинг гэсэн 15 чиглэлд хуваан бэлтгэл ажлыг бүрэн ханган ажиллаж амжилттай зохион байгууллаа. Үр дүн: "Улаанбаатар -2023" Зүүн Азийн Залуучуудын наадмыг эх орондоо анх удаа зохион байгууллаа.			
Хэрэгжилтийн дундаж:									98,6			

ТАНИЛЦСАН:
НИЙСЛЭЛИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

ТАЙЛАН ХЯНАСАН:
ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТ, САНХҮҮГИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:
ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТ, САНХҮҮГИЙН
ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН



С.САРАНЦЭЦЭГ

М.ЦОГЗОЛМАА

Г.БЯМБАСАЙХАН

НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗАР

ТАНИЛЦУУЛГА

2024 оны 12 дугаар сарын 16

Улаанбаатар хот

"НИЙСЛЭЛИЙГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ" ДУНД ХУГАЦААНЫ ТӨЛӨВЛӨЛТИЙН БАРИМТ БИЧГИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН 2021-2024 ОНЫ ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТУХАЙ

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО.

"Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл" дунд хугацааны төлөвлөлтийн баримт бичгийн шалгуур үзүүлэлтийн 2021-2024 оны хэрэгжилтэд тухайн онд тавьсан зорилт, хүрэх түвшин, шалгуур үзүүлэлттэй харьцуулан тооцож, үр дүнг үнэлэн, дүгнэлт өгч, удирдлагыг үнэн бодит мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, хариуцлагыг сайжруулахад хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго оршино.

ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ.

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ыг удирдлага болгов.

"Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл" дунд хугацааны төлөвлөлтийн баримт бичгийн шалгуур үзүүлэлтийн 2021-2024 оны хэрэгжилтэд биеийн тамир, спортын чиглэлээр туссан арга хэмжээний хүрээнд хийсэн ажлын тайлантай танилцаж, хяналт-шинжилгээ, үнэлгээг гүйцэтгэв.

Төлөвлөсөн арга хэмжээ бүрийг тухайн жилд хэрэгжүүлсэн ажлын бодит үр дүнг, хүрэх түвшинтэй харьцуулан биелэлтийг хувиар тодорхойлж, зорилтын хэрэгжилтийг шилжүүлэн тооцлоо.

ГУРАВ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН.

"Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл" дунд хугацааны төлөвлөлтийн баримт бичгийн шалгуур үзүүлэлтийн 2021-2024 оны хэрэгжилтэд 5 арга хэмжээг хяналтад авч тэдгээрийн 2024 оны биелэлтийн явцыг Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206, 2021 оны 374 дүгээр тогтоолын дагуу явцын үнэлгээ хийнэ.

(Хүснэгт)

№	Хэрэгжүүлж буй арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Гүйцэтгэлийн хувь
3.5.1	Нийслэлийн хүн амд үзүүлэх биеийн тамир, спортын үйлчилгээний чанар сайжирсан байна.	Биеийн тамирын арга зүйчийн тоо	Биеийн тамирын 9 арга зүйчтэй болсон байна.	Хуулинд тусгагдсан	90%
		Магадлан итгэмжлэгдсэн спорт клубын тоо	23	13	90%
		Иргэдийн бие бялдрын	58%	80%	100%

		хөгжлийн суурь үзүүлэлт			
		Зорилтын дундаж хувь			93.3%
3.5.2	Дүүрэг, хороод болон шинэ дагуул хот, шинэ дэд төвүүдэд биеийн тамир, спортын барилга байгууламжийг норм, стандартын дагуу барьж байгуулсан байна.	Төрөлжсөн спортын талбай	104	203	100%
		Спортын барилга байгууламжийн хүртээмж Мкв	64	65	100%
		Зорилтын дундаж хувь			100%
3.5.3	Нийслэлийн иргэдийн дунд биеийн тамир, спортын арга хэмжээнүүдийг зохион байгуулснаар оролцоог нэмэгдүүлсэн байна.	Хамрагдсан иргэдийн тоо	830,080	888,500	100%
		Зорилтын дундаж хувь			100%
3.5.4	Нийслэлд спортын төрлүүдийг хөгжүүлж, тамирчдын залгамж халааг тасралтгүй бэлтгэдэг болсон байна.	Тэмцээнд оролцсон тамирчид	152,340	166,634	100%
		Өсвөрийн шигшээ багуудын спортын төрөл	24	28	100%
		Зорилтын дундаж хувь			100%
3.5.5	Нийслэл Улаанбаатар хотноо олон улсын спортын наадмыг зохион байгуулж дэлхийд сурталчлан таниулах ажлыг шат дараатай зохион байгуулсан байна.	Улаанбаатар хотноо зохион байгуулж буй Олон улсын спортын наадам зохион байгуулах	"Улаанбаатар -2023" Зүүн азийн залуучуудын наадмыг зохион байгуулсан байна.	"Улаанбаатар -2023" Зүүн Азийн Залуучуудын наадмыг эх орондоо анх удаа зохион байгууллаа.	100%
		Зорилтын дундаж хувь			100%
Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 3.5. дахь зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны 2024 оны эцсийн хэрэгжилтийг 98.6 хувьтай буюу "тодорой үр дүнтэй" гэж үнэллээ.					


ДӨРӨВ. ДҮГНЭЛТ:

"Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл" дунд хугацааны төлөвлөлтийн баримт бичгийн шалгуур үзүүлэлтийн 2021-2024 оны хэрэгжилтэд 5 хүрэх үр дүн, 9 шалгуур үзүүлэлтийг хангахаар тусгасан. Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 3.5. дахь зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны 2024 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 98.6 хувьтай буюу "тодорой үр дүнтэй" гэж үнэллээ.

ТАНИЛЦСАН:

НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  С.САРАНЦЭЦЭГ

ХЯНАСАН:

ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТ, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА  М.ЦОГЗОЛМАА

**ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:**

ХҮНИЙ НӨӨЦ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН

 Б.ОЮУНТУЯА

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын
 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн
 02/2024 дүгээр албан бичгийн
 зургаадугаар хавсралт



НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗАР
 ХУУЛЬ, ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН 2024 ОНЫ ТАЙЛАН

2024 оны 12 дугаар сарын 16

Улаанбаатар хот

№	Зүйл, заалтын дэс дугаар	Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга	Хэрэгжилтийн явц	Үнэлгээ (хүчингүй болсон, хяналтаас хасуулах тухай санал)	Тасарсан болон удааширч байгаа шалтгаан
1	2	3	4	5	
1.МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ					
1.	7 дугаар зүйлийн 7.1.1-7.1.3 дугаар заалт	2017 оны 07 дугаар сарын 06 Биеийн тамир, спортын тухай хууль 7.Биеийн тамир, спортыг хөгжүүлэхэд иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ;	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас биеийн тамир, спортыг хөгжүүлэх зорилгоор Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд 1 зорилт 5 шалгуур үзүүлэлт тусгаж 2020 оны 02/09 дүгээр тогтоолоор, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт 3 зорилт 15 арга хэмжээ тусгаж 2020 оны 02/10 дугаар тогтоолоор баталсан. Дээрх зорилт, шалгуур үзүүлэлт, арга хэмжээг Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын 2021-2024 оны стратеги төлөвлөгөө, 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлснээр таван жилийн үндсэн чиглэлийн биелэлт болон үйл ажиллагааны хөтөлбөр жилийн эцсээр нэгтгэгдэж байна. 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 2 зорилго 10 зорилт 49 ажил, арга хэмжээтэйгээр баталж 2024 оны жилийн эцсийн байдлаар гүйцэтгэлийн дундаж 97 хувьтай байна. Хэрэгжилт 100%	100%	-
2.	8 дугаар зүйлийн 8.1.1-8.1.8 дугаар заалт	2017 оны 07 дугаар сарын 06 Биеийн тамир, спортын тухай хууль 8.Аймаг, нийслэлийн Засаг дарга биеийн тамир, спортыг хөгжүүлэх талаар дараах заалтуудыг хэрэгжүүлнэ;	Биеийн тамир, спортын тухай хуульд туссан Нийслэлийн Засаг даргын хариуцах чиг үүргийг Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын дүрэмд тусган А/154 дүгээр захирамжаар баталгаажуулан 12 үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхээр 14 ажил бүхий төлөвлөгөө гарган ажилласан. Биеийн тамир, спортын тухай хуулийг 2024 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 14 ажил, арга хэмжээтэйгээр баталж жилийн эцсийн байдлаар хэрэгжилт 98% хувьтай байна. Хэрэгжилт 100%	100%	-
		2017 оны 07 дугаар сарын 06	Өндөр зэрэгтэй тамирчдын залгамж халааг тасралтгүй бэлтгэх, биеийн тамир, спортын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж дүүргийн Засаг даргын дэргэдэх Өсвөрийн шигшээ багийн бүрэлдэхүүнийг шинэчлэн		

3.	18 дугаар зүйлийн 18.3 дугаар хэсэг	Биеийн тамир, спортын тухай хууль 18.3.Аймаг, дүүргийн Засаг дарга нь аймаг, дүүргийн өсвөр үеийн шигшээ багт орон нутгийн төсвөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх бөгөөд аймаг, дүүргийн Биеийн тамир, спортын газар нь спортын 8-аас доошгүй төрлөөр спортын холбооны орон нутаг дахь салбартай хамтран сонгон шалгаруулж, үйл ажиллагааг нь зохион байгуулна;	байгуулж спортын 28 төрөлд 109 багт 109 дасгалжуулагчтай 3525 тамирчдыг бэлтгэл сургуулилтад хамруулж байна. Өсвөрийн шигшээ багийн тамирчид 2024 оны жилийн эцсийн байдлаар тив, дэлхий, олон улс, улс, нийслэл, нэрэмжит 521 удаагийн тэмцээнд оролцож 2707 медаль авсан амжилт үзүүлсэн бол Баянзүрх, Сүхбаатар, Сонгинохайрхан, Хан-Уул, Чингэлтэй, Багануур, Налайх, Налайх дүүрэг өсвөрийн шигшээ багийн үйл ажиллагааг дэмжиж 288.230.241 (хоёр зуун наян найман сая хоёр зучин мянган хоёр зуун дөчин нэгэн мянган) төгрөгийг зарцуулсан байна. Хэрэгжилт 100%	100%	-
Хэсгийн дундаж		100%		100%	
2.МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ					
1.	1 дүгээр зүйл	2010 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 53 дугаар зарлиг Нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх тухай 1.Монгол Улсын хүн амын орчин үеийн эрүүл амьдралын хэв маяг, зан үйлд сургах, аливаа саад, бэрхшээлийг даван туулах бие, сэтгэлийн тэсвэр хатуужилтай шинэ үеийг бий болгох зорилгоор “Хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил”-ыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар жил бүрийн дөрөвдүгээр сард явуулж, үнэлэлт, дүгнэлтийг үндэслэн шаардлагатай арга хэмжээг авч ажиллахыг;	Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 53 дугаар зарлигийн дагуу бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил авах ажлыг нийслэлийн хэмжээнд 2024 оны IV-VI, IX-XII саруудад зохион байгуулж 193,000 иргэн хамрагдсан бол сорилд хамрагдсан нийт иргэдийн 82 хувь нь А, В, С үнэлгээ авсан үзүүлэлттэй үнэлэгдсэн. 2024 онд Баянгол, Налайх дүүрэгт сорилын шинэ төв байгуулагдсан. Энэ төв нь иргэдийн бие бялдрын түвшин тогтоох сорилыг орчин үеийн тоног төхөөрөмжөөр авах бөгөөд бие бялдрын ажиллах чадвар, бүтцийг тодорхойлох юм. Хэрэгжилт 100%	100%	-
2.	4 дүгээр зүйл	2014 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 27 дугаар зарлиг Засгийн газарт чиглэл өгөх тухай 4.Өвлийн спортын барилга байгууламжийн цогцолборт түшиглэн уралдаан, тэмцээн зохион байгуулах, Монгол Улсын тамирчид гадаад улсын баг, тамирчидтай бэлтгэл хийх, хамтран ажиллахыг хөхиүлэн дэмжихийг;	Өвлийн улиралд иргэдийн бие бялдыг чийрэгжүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлэн 2024 оны жилийн эцсийн байдлаар 414,200 иргэнд үйлчилгээ үзүүлж ажилласан байна. Үүнд: Нийслэлийн 9 дүүрэгт өвлийн спортын нийтийг хамарсан 10 арга хэмжээ зохион байгуулж 25.909 иргэнийг хамруулсан. Улаанбаатар хотын аварга шалгаруулах уралдаан өвлийн спортын 7 төрлөөр зохион байгуулж 693 тамирчдыг хамруулсан. Дүүргүүдийн Засаг даргын дэргэдэх Өсвөрийн шигшээ багт өвлийн спортын 3 төрөл (хоккей, тэшүүр, шорт-трейк)-ийн төрлөөр 95 хүүхэд, багачууд секц, дугуйланд хамрагдсан. Монголын Тэшүүр, Хоккейн холбооны дэргэдэх бүртгэлтэй дугуйлан, секцэд 175 хүүхэд спортын 3 (тэшүүр, хоккей, уран гулгалт) төрөлд хамрагдаж байна. Хан-Уул, Чингэлтэй дүүрэгт байрлах битүү дээвэртэй мөсөн гулгуурын талбайд 2024 оны 01 дүгээр сарын 02-ноос 12 дугаар сарын 02-ны хооронд 129.054 иргэн үйлчлүүлсэн байна. Сүхбаатар, Баянзүрх, Багануур дүүрэг дэх Хандгайт, Скай ресорт, Галуут тур, Улаанбаатар	100%	-

			цанын баазуудад 153.000 иргэн үйлчлүүлсэн. Орон сууц, гэр хорооллын 22 байршилд мөсөн гулгуурын талбай байгуулагдаж 105.544 иргэнд үйлчилгээ үзүүлсэн байна. Хэрэгжилт 100%		
3.	1 дүгээр зүйл	2015 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн 144 дүгээр зарлиг Засгийн газарт чиглэл өгөх тухай 1.Үндэсний болон хөлбөмбөг, хоккейн спортыг хөгжүүлэх орчин үеийн шаардлага, стандартыг хангасан барилга байгууламжийн цогцолборыг нийслэл Улаанбаатар хот болон боломжтой бусад суурин газарт бариулах, газрын асуудлыг шийдвэрлэх, дотоод, гадаадын зохих хөрөнгө оруулалтыг төр, хувийн хэвшлийн түншлэл, хамтын ажиллагаанд тулгуурлан шийдвэрлэх;	Хөлбөмбөгийн спортыг хөгжүүлэх зорилгоор нийслэлийн ЕБС-иудын биеийн тамир, спортын гадна талбайн судалгаанд үндэслэн 2021 онд ЧД-н 24, 2022 онд СБД-н 2, ХУД-н 34, 52, 2023 онд ЧД-н 57, СХД-н 67, ХУД-75 дугаар сургуулийн гадна талбайг дүүргийн ЗДТГ-н санхүүжилтийг олгуулж суурийн ажлыг гүйцэтгэн, Монголын Хөлбөмбөгийн холбоотой хамтран ОУ-ын стандарт шаардлага хангасан хөлбөмбөгийн талбайг тохижуулсан. 2024 онд Баянгол дүүргийн Оюуны ундраа цогцолбор сургуулийн гадна талбайг үерийн далан байгуулах ажлыг хийсний дараа тохижуулахаар хүлээгдэж байна. Хоккейн спортыг хөгжүүлэх орчин үеийн шаардлага, стандартыг хангасан барилга байгууламж барих зорилгоор Засгийн газрын тохируулагч агентлаг – Биеийн тамир, спортын Улсын хорооны захиалгаар хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар Хан-Уул дүүргийн 8-р хороонд орчин үеийн стандарт шаардлагыг хангасан, өвлийн спортын битүү дээвэртэй, 7800м ² ашигтай талбайтай, 2500 хүний суудалтай “Степпе Арена” мөсөн өргөө, Чингэлтэй дүүргийн спорт цогцолборын “С” блок буюу хоккейн талбай ашиглалтад орж жилийн 4 улиралд үйл ажиллагаа явуулж байна. Хэрэгжилт 100%	100%	-
4.	1 дүгээр зүйлийн 1.8 дахь хэсэг	2022 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 43 дугаар зарлиг Засгийн газарт чиглэл өгөх тухай 1.8.Иргэд, хүүхэд залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрөөх, биеийн тамир, спортоор хичээллэх орчин нөхцөлийг бүрдүүлэхэд зохион байгуулалт, хөрөнгө санхүүгийн дэмжлэг үзүүлж, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж, байгууллагуудыг дэмжин хамтран ажиллах;	1.Биеийн тамир, спортын гадна талбайн хүрээнд: Стандарт шаардлагад нийцсэн биеийн тамир, спортын гадна талбай 2021 онд 101 байсан бол 2022 онд 4-өөр нэмэгдэж 105 болсон буюу Хан-уул дүүргийн 8 дугаар хороонд хөлбөмбөгийн талбай бүхий техникийн төв, Сүхбаатар дүүргийн 2-р сургууль, Хан-Уул дүүргийн 34, 52-р сургуулиудын гадна талбайг хөлбөмбөгийн талбайгаар шинэчлэн тохижуулсан, 2023 онд 36 талбайгаар нэмэгдэж 140 буюу Чингэлтэй дүүргийн 57, Сонгинохайрхан дүүргийн 67-р сургуулийн спорт талбай мөн Нийслэлийн Засаг даргын санаачилгаар 3х3 сагсан бөмбөгийн 34 талбайг 2022 оноос тохижуулж эхлэн 2023 оны 06 дугаар сард ашиглалтад орсон. 2024 оны жилийн эцсийн байдлаар биеийн тамир, спортын зориулалтын гадна талбай 203 буюу Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/490 дүгээр захирамжаар 40 байгуулахаар Нийслэлийн Хот тохижилтын газар хариуцан ажиллаж 40 талбай ашиглалтад орсон. 2.Спортын барилга байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд: Нийслэлийн хэмжээнд 1000 хүнд оногдох спортын барилга байгууламжийн хүртээмж 2019 онд 60мкв байсан бол 2020 онд 60.5мкв, 2021 онд 61м ² , 2022 онд 62мкв 2023 онд 63,5мкв, 2024 оны эхний хагас жилд 63.5мкв байна. Үүнд Хан-уул дүүргийн 1 дүгээр хороо нүхтийн зам дагуу 508 мкв талбай бүхий MINT sport Club, Хан-уул дүүргийн 2 дугаар	100%	-

			<p>хороо Говийн зам дагуу 600мк талбай бүхий B3 NBA спорт заал, Хан-уул дүүргийн 3 дугаар хороонд 833 мкв талбай бүхий Emart спорт заал, Хан-Уул дүүргийн 1 дүгээр хороонд 812 мкв талбай бүхий Наадам спорт клуб, Сүхбаатар дүүргийн 11-р хороо 672 мкв талбай бүхий Хангай хотхонд Shine sport center спорт заал, Сонгинохайрхан дүүргийн 20-р хороонд 540 мкв талбай бүхий "ОБ" спорт заал, Сонгинохайрхан дүүргийн 4 дүгээр хороонд Толгойт хөгжлийн төвийн 1 давхарт спорт заал, Сонгинохайрхан дүүргийн 29-р хороонд 800 мкв талбайтай "City" спорт заал ашиглалтад орсон бол Баянхошуу дэд төв буюу Сонгинохайрхан дүүргийн 40 дүгээр хороонд баригдах 650 хүний суудалтай спорт цогцолборын барилгын ажлын гүйцэтгэл 70 хувьд хүрсэн байна.</p> <p>Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж буй Багахангай дүүргийн 2 дугаар хорооны спорт цогцолборын барилгын ажлын гүйцэтгэгчээр "Алтан шар говь" ХХК шалгарч 2022 онд 500.0 сая, 2023 онд 815.6 сая, 2024 онд 1,100.0 сая төгрөгийн санхүүжилтээр барилгын ажлын 80%, Налайх дүүргийн 1-р хорооны нутаг дэвсгэрт баригдаж буй спорт цогцолборын барилгын ажлын гүйцэтгэгчээр "Бүрд констракшн" ХХК ажиллаж 15.0 тэрбум төгрөгийн төсөвт өртгөөр байгуулж 100%, Баянзүрх дүүргийн спортын ордны бүтээн байгуулалтын ажил 85 хувьтай үргэлжилж байна.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт 100%</p>		
Хэсгийн дундаж			100%	100%	
3.МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ					
1.	2 дугаар зүйл	<p>2018 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 183 дугаар тогтоол Журам батлах тухай Улсын хэмжээний спортын наадам зохион байгуулах бэлтгэл ажлыг хангах, шаардлагатай хөрөнгө оруулалтыг бодлогоор дэмжин улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, жил бүрийн улсын болон орон нутгийн төсөвт тусган, шийдвэрлэж ажиллахыг;</p>	<p>Монгол Улсын Засгийн газрын 2018 оны "Улсын хэмжээний спортын наадам зохион байгуулах тухай" 183 дугаар тогтоолын дагуу 2024 онд оюутны спортын их наадмыг спортын 10 төрөл(волейбол, гандбол, жүдо бөх, сагсан бөмбөг 5х5, таеквондо, футзал, чирлидинг, чөлөөт бөх, шатар, ширээний теннис) -өөр 2024 оны 04 дүгээр сарын 16-наас 26-ны өдрүүдэд Засгийн газрын тохируулагч агентлаг – Биеийн тамир, спортын улсын хороо хариуцан зохион байгуулж 2000 орчим тамирчин 533 багц медалийн төлөө өрсөлдсөн.</p> <p>Засгийн газрын тохируулагч агентлаг – Биеийн тамир, спортын газрын даргын 2024 оны А/65 дугаар тушаалаар "Монголын оюутны спортын VI наадмын нэгдсэн заавар"-ыг бүрэлдэхүүн сургуулийн болон шигшээ тэмцээн гэсэн 2 үе шаттай баталсан.</p> <p>Наадам зохион байгуулах бэлтгэл ажлын төлөвлөгөөнд тусгагдсан нийслэл хариуцан гүйцэтгэх 2 чиглэлийн 5 ажлыг бие даан болон холбогдох байгууллагуудтай хамтран гүйцэтгэсэн.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт 100%</p>	100%	-
2.		<p>2019 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 204 дүгээр тогтоол Журам батлах тухай</p>	<p>"Тамирчдын баяр"-ыг 2024 оны 06 дугаар сарын 30-нд тэмдэглэн Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Биеийн тамир, спортын Улсын хороо хариуцан зохион байгуулсан.</p>	100%	-

	2 дугаар зүйл	2."Түүхэн үйл явдал, тэмдэглэлт өдөр"-ийн жагсаалтыг 1 дүгээр хавсралт, тэмдэглэн өнгөрүүлэх журмыг 2 дугаар хавсралтаар баталж хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг;			
			Хэрэгжилт 100%		
3.	2 дугаар зүйл	2019 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 33 дугаар тогтоол 2."Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм"-ийг хавсралтаар баталж байгууллагын дотоод журмыг энэ тогтоолоор баталсан дүрэмд нийцүүлэх;	2019 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 33 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм"-ийн ёс зүйн хэм хэмжээ, төрийн албан хаагчдад тавигдах ёс зүйн шаардлагын 3.1.1.а – 3.1.1.ё-д заасан шаардлагуудыг байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд тусган 2022 оны А/43 дугаар тушаалаар баталгаажуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Энэ хүрээнд 2024 оны жилийн эцсийн байдлаар ёс зүйн зөрчил гаргасан албан хаагч байхгүй бөгөөд иргэд, аж, ахуйн нэгж байгууллагаас албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол, мэдээлэл ирээгүй байна.	100%	-
			Хэрэгжилт 100%		
4.	3 дугаар зүйл	2020 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 163 дугаар тогтоол 3.Төрийн албан хаагчийн цалин хөлсний бүрэлдэхүүн, албан тушаалын ангилал, шатлал, зэрэглэл болон цалин хөлс тооцоолоход шаардагдах бусад мэдээлэлд өөрчлөлт орсон тухай бүрт өөрчлөлтийг хүний нөөцийн удирдлагын мэдээллийн системд үнэн зөв байдлаар оруулж, мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангаж ажиллахыг;	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 84, 128 дугаар тогтоолоор албан хаагчдын цалин хөлс, албан тушаалын ангилал, шатлал, зэрэглэл болон цалин хөлс тооцоолоход шаардагдах өөрчлөлт, шилжилт хөдөлгөөний бүртгэлийг 9 удаа давхардсан тоогоор 30 албан хаагчийн мэдээллийг төрийн албаны зөвлөлийн "Хүний нөөцийн удирдлагын систем"-д шинэчилж оруулсан.	100%	-
			Хэрэгжилт 100%		
5.	1 дүгээр зүйлийн 1.1 дэх заалт	2018 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн 258 дугаар тогтоол Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай 1.1.харьяа байгууллага болон салбар, нэгжид сахилга, дэг журмыг сахиулах тодорхой арга хэмжээ авч, төрийн албаны хууль тогтоомж, холбогдох дүрэм, журмыг зөрчсөн албан хаагчид хариуцлага тооцож тухай бүр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тайлагнаж байх;	Байгууллагын ёс зүйн дэд хорооны зөвлөл нь 3 гишүүнтэй, 2024 оны "Ёс зүйн хороо"-ны төлөвлөгөөг 11 үйл ажиллагаатайгаар 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр батлан хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. 2024 оны жилийн эцсийн байдлаар ёс зүйн зөрчил гаргасан албан хаагч байхгүй бөгөөд иргэд, аж, ахуйн нэгж байгууллагаас албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол, мэдээлэл ирээгүй байна.	100%	-
			Хэрэгжилт 100%		
6.		2018 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн 258 дугаар тогтоол Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай	Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/1059 дүгээр захирамжаар Нийслэлийн Биеийн тамир, спортын газрыг 2 хэлтэс 16(үүнээс дарга 1) албан хаагчийн бүрэлдэхүүнтэйгээр орон тооны хязгаарыг баталсны дагуу Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 357 дугаар тогтоолоор төрийн жинхэнэ албан хаагчийн 13 албан тушаалын тодорхойлолтыг батлуулсан.	100%	-

	1 дүгээр зүйлийн 1.3 дахь заалт	1.3.төрийн албан хаагчдын ажлын байрны шинжилгээ хийж, шинжилгээний дүнд тулгуурлан байгууллагын чиг үүргийн давхардал, хийдлийг арилгаж, ажлын бүтээмж, үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах;	Энэ дагуу 2022 оны А/20 дугаар тушаалаар төрийн захиргааны 13, төрийн үйлчилгээний 2 нийт 15 албан тушаалын тодорхойлолтыг баталж албан хаагчдыг байршуулан тухайн албан тушаалын тодорхойлолтын дагуу ажиллаж байна. Байгууллагын бүтэц орон тоо, цалингийн хэмжээ, нэмэгдлийг 2024 оны А/01 дүгээр тушаалаар шинэчлэн тогтоож хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хэрэгжилт 100%		
7.	1 дүгээр зүйлийн 1.4 дэх заалт	2018 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн 258 дугаар тогтоол Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай 1.4.төрийн жинхэнэ албан тушаалд сул орон тоо гарсан тохиолдолд тухайн байгууллага болон төрийн холбогдох байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдаас үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингээр шалгаруулж нөхөн томилох замаар төрийн мэргэшсэн албыг бэхжүүлэх;	Байгууллагын хэмжээнд дэс түшмэлийн албан тушаалын 5 сул орон тоог нөхөн бүрдүүлэхээр нийтэд нээлттэй зарлаж, сул орон тооны мэдээлэл, сонгон шалгаруулалтын захиалгыг Төрийн албаны Зөвлөлийн Нийслэл дэх салбар зөвлөлд 2024 онд 4 удаа хүргүүлж, сул орон тооны зарыг төрийн албаны сайт, дотоод удирдлагын нэгдсэн программ ERP систем болон байгууллагын сайтад байршуулсан. Байгууллагад ажиллаж байгаа албан хаагчдаас албан тушаалын чиг үүрэг нь хамгийн ойр хамаарал бүхий 4 албан хаагчдаар бусад сул орон тоог түр орлон гүйцэтгүүлж байна. Хэрэгжилт 100%	100%	-
8.	1 дүгээр зүйлийн 1.6 дахь заалт	2018 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн 258 дугаар тогтоол Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай 1.6.төрийн жинхэнэ албан хаагч жирэмсний болон амаржсаны амралттай байгаа, эсхүл 3 сараас дээш хугацааны сургалтад хамрагдаж сул орон тоо гарснаас бусад тохиолдолд төрийн албаны сул орон тоонд гэрээт ажилтан томилохгүй байх зарчим баримталж, төрийн байгууллагад албан ажлын зайлшгүй шаардлагыг үндэслэн богино хугацаагаар ажиллуулахаас бусад тохиолдолд гэрээт ажилтан ажиллуулахгүй байх;	Нийслэлийн Биеийн тамир, спортын газарт 2024 онд жирэмсний болон амаржсаны амралт авсан нэг албан хаагчийн сул орон тоонд өөр байгууллагын албан хаагчийг шилжин сэлгүүлэн ажиллуулж байна. Удирдлагын академийн төрийн албан хаагчдыг чиглүүлэх сургалтад 3 албан хаагчийг хамруулж, зардлыг улсын төсвөөс шийдвэрлүүлсэн. Сул орон тоонд гэрээт ажилтан авч ажиллуулаагүй болно. Хэрэгжилт 100%	100%	-

9.	1 дүгээр зүйлийн 1.7 дахь заалт	<p>2018 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн 258 дугаар тогтоол</p> <p>Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай</p> <p>1.7.төрийн албан хаагч албан томилолтын явцад, ажлын болон ажлын бус цагаар ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэх явдлыг таслах зогсоох, төрийн байгууллагын байр, ажлын байранд согтууруулах ундаа, мансууруулах бодис, галт болон хүйтэн зэвсэг, тэсэрч дэлбэрэх болон шатамхай бодис, хэрэгслийг нэвтрүүлэх, хадгалах, хэрэглэх, ашиглахыг байгууллагын дотоод журамд тусган хориглож, зөрчсөн тохиолдолд хариуцлага тооцох;</p>	<p>Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын дотоод журмын 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэгт ажлын болон ажлын бус цагаар ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэх, төрийн байгууллагын байр, ажлын байранд согтууруулах ундаа, мансууруулах бодис, галт болон хүйтэн зэвсэг, тэсэрч дэлбэрэх болон шатамхай бодис, хэрэгслийг нэвтрүүлэх, хадгалах, хэрэглэх, ашиглахыг тусган хориглож, зөрчсөн тохиолдолд хариуцлага тооцох асуудлыг тусгаж нийт албан хаагчдад танилцуулан мөрдлөг болгон ажиллаж байна.</p> <p>2024 онд зохион байгуулсан нийтийг хамарсан 17 арга хэмжээ, Улаанбаатар хотын аварга шалгаруулах 17 уралдаан, тэмцээнийг "Архитамхигүй" уриан дор зохион байгуулж энэ хүрээнд "Улаанбаатар лиг" волейболын шигшээ тэмцээний үеэр дүүргийн биеийн тамир, спортын хорооны нэг мэргэжилтэн архи, согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн тул тухайн өдөр ажиллуулах боломжгүй талаар мэдэгдэж сануулга өгч зөрчлийг арилгуулсан.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт 100%</p>	100%	-
10.	1 дүгээр зүйлийн 1.8 дахь заалт	<p>2018 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн 258 дугаар тогтоол</p> <p>Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай</p> <p>1.8.төрийн албан хаагчдын үйлдсэн гэмт хэрэг, гаргасан зөрчил, сахилга, ёс зүйн зөрчилд судалгаа, дүн шинжилгээ хийж, шалтгаан нөхцөлийг тогтоон, урьдчилан сэргийлэх арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах;</p>	<p>2024 оны жилийн эцсийн байдлаар ёс зүйн зөрчил гаргасан албан хаагч байхгүй бөгөөд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол, санал ирээгүй байна.</p> <p>Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 2024 онд төрийн албан хаагчийг ёс зүйтэй холбогдолтой 6 удаагийн сургалтад давхардсан тоогоор 20 албан хаагч хамрагдсан.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт 100%</p>	100%	-
11.	5 дугаар зүйлийн 5.1 дэх заалт	<p>2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 07 дугаар тогтоол</p> <p>Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай</p> <p>5.1.эрх бүхий судалгааны байгууллагатай хамтран салбарын мэргэжлийн нэр томъёог орчуулах, шинээр үүсгэх, жигдлэх, томилох ажлыг зохион байгуулах, нийтийн хэрэглээнд нэвтрүүлэх;</p>	<p>Биеийн тамир, спортын салбарын мэргэжлийн нэр томъёог орчуулах ажлын хүрээнд "Улаанбаатар марафон-2024" олон улсын гүйлтийн удирдамжийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтэс, Хай пей ХХК-тай хамтран доктор Л.Нямын гаргасан "Монгол-Орос-Англи" хэлний мэргэжлийн нэр томъёоны тайлбар толь"-ийг ашиглан кирилл, монгол бичиг, англи хэлээр хөрвүүлэн https://sport.ub.gov.mn/ сайтад байршуулж 1617 хүнд хүргэсэн байна.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт 100%</p>	100%	-
4.	1	Нийслэлийн эрх зүйн мэдээллийн нэгдсэн санг эрхлэн хөтлөх журам батлах тухай 2017 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 90 дүгээр тогтоол	Нийслэлийн эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан https://ublegal.ulaanbaatar.mn/ -д Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын хэмжээнд 2024 оны жилийн эцсийн байдлаар хүний нөөцийн чиглэлээр гарсан Б тушаал 22, үндсэн үйл ажиллагааны чиглэлээр гарсан А тушаал 48-ыг файлаар болон бичвэр хэлбэрээр оруулж ил тод байдлыг хангаж, иргэдийг мэдээллээр ханган ажилласан байна. Хэрэгжилт 100%	100%	-
5.	1	Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн хүртээмжийг сайжруулах тухай 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 210 дугаар тогтоол	Нийслэлийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг биеийн тамир, спортын тэмцээн, уралдаанд тэгш хамруулах чиглэл бүхий төлөвлөгөө гарган ажиллаж нийслэл, дүүргийн хэмжээнд нийт 42 арга хэмжээ зохион байгуулж 664 байгууллагын 2404 иргэн хамрагдаад байна. Дээрх арга хэмжээнүүдэд нийт 46.637.100 төгрөгийг зарцуулсан. Үүнээс: Улаанбаатар хотын аварга шалгаруулах пара бадминтон, пара бочи, хонхтой бөмбөгийн төрлүүдээр зохион байгуулж 23 байгууллагын 115 тамирчин оролцож улсын төсвөөс 4,800,000.0 төгрөгийг зарцуулсан бол “Улаанбаатар марафон 2024” олон улсын гүйлтийг 2024 оны 05 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулж хөгжлийн бэрхшээлтэй болон тусгай хэрэгцээт иргэдийн 7 ангилал (тусгай олимпын төрөл 500 м -т 36 хүн, 800 м -т 20 хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэд 1500 м -ийн зайд (хараагүй) 34 хүн, (тэргэнцэртэй) 17 хүн, 21,095 км -т 30 тамирчин, 42,195 км -т 10 тамирчин, гар дугуйн ангилалд 5 тамирчин)-д нийт 152 хүн оролцлоо. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг биеийн тамир, спортоор	100%	-

			хичээллэх орчин нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр спорт заал, зориулалтын талбайг нээлттэй, үнэгүй ашиглуулах, секц дугуйланг шинээр байгуулах чиглэлээр зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж зөвлөмж гарган дүүргийн Биеийн тамир, спортын хороодод 2024 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 02/71 дүгээр албан бичгээр хүргүүлсэн. Энэ хүрээнд 2024 онд Чингэлтэй, Сонгинохайрхан, Баянгол, Багануур, Багахангай, Налайх, Хан-Уул, 7 дүүргийн биеийн тамир, спортын хороод ашиглалтыг нь хариуцаж байгаа 7 спорт цогцолбор, Баянзүрх, Сүхбаатар дүүргүүд нутаг дэвсгэр дээрээ үйл ажиллагаа явуулж байгаа 7 спорт заал, 2 усан бассейнд үнэ төлбөргүйгээр 7 хоног бүр хуваарьт цаг гарган нийт 55 байгууллагын 642 иргэнд тогтмол үйлчилгээ үзүүлэн ажиллаж байгаа бол даам, хонхот бөмбөг, бочи, хэрэглэлтэй сэлэм, фитнес, суугаа волейбол, ширээний теннис, туялзуур сэлэм, тусгай олимпын төрөл, парабадминтон гэсэн 10 төрлөөр секц, дугуйланг хичээллүүлж 21 байгууллагын 160 иргэнийг тогтмол хичээллүүлсэн байна. Хэрэгжилт 100%		
Хэсгийн дундаж			100%		
3.НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ					
6.	2	2006 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн А/164 дугаар захирамж Хөдөлгөөний хомсдолоос шалтгаалах өвчлөлийг багасгах тухай Нийслэлийн хүн амын эрүүл мэндийг бэхжүүлэх, хөдөлгөөний хомсдолоос шалтгаалан үүсэх өвчлөлийг багасгах, урьдчилан сэргийлэхэд биеийн тамир, спортын дасгал хөдөлгөөнөөр хичээллэх ач холбогдлыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн бүх нийтээр хий хэвшүүлэх өглөө, өдрийн болон ажлын байранд алжаал тайлах дасгалыг боловсруулан гаргаж, олон түмэнд хүргэх, хийж сургахыг;	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын албан хаагчдын бие бялдрыг чийрэгжүүлэх, спортын дасгал хөдөлгөөнийг тогтмол хийж хэвшүүлэх зорилгоор Монголын Спорт сонирхогч хөгжөөн дэмжигчдийн холбоотой хамтран ажлын байранд хийх дасгалыг боловсруулан дотоод удирдлагын нэгдсэн ERP системд байршуулан 11:00, 13:00 цагуудад гарган, байгууллагуудыг тогтмол хийж хэвшихийг уриалан ажилласан байна. Хэрэгжилт 100%	100%	-
7.	3	2006 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн А/165 дугаар захирамж Хамтлаг байгуулах тухай Тухайн аж ахуй нэгж, байгууллага, хороодод дээрх чиглэлээр хийгдэж буй үйл ажиллагаанд хяналт	2024 онд нийслэлийн хэмжээнд 2 (БЗД-ийн 12-р хороо, 41-р хороо) хамтлаг шинээр байгуулагдаж нийт 810 биеийн тамир, спортын хамтлаг үйл ажиллагаа явуулж байна. Биеийн тамир, спортын хамтлагийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, нийтэд таниулах, урамшуулах зорилгоор 6 хамтлагийг “Нийслэлийн шилдэг биеийн тамир, спортын хамтлаг”-аар шалгаруулан өргөмжлөл, цом, мөнгөн шагналаар шагнаж урамшуулсан бол хамтлагийн үйл ажиллагаанд тулгуурлан “Улаанбаатар марафонд нэгдэцгээ” цомын аяныг Баянзүрх, Сонгинохайрхан,	100%	-

		тавьж, удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг;	Сүхбаатар дүүргийн хэмжээнд аялуулж, 123 удаагийн биеийн тамир, спортын уралдаан тэмцээн, өдөрлөг зохион байгуулж, 316 байгууллагын 63140 албан хаагчийг хамруулсан. Хэрэгжилт 100%		
8.	1.1.	2022 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн А/763 дугаар захирамж Хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд хөгжих, тоглох эрхийг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, орон сууцны хорооллын гадна байрлах биеийн тамир, спортын болон тоглоомын талбай, ногоон байгууламжийг өдөр бүр 06.00-22:00 цагийн хооронд нээлттэй байлгаж, хүүхэд тоглох, ашиглах нөхцөлийг бүрдүүлэх, аюулгүй байдалд хяналт тавьж ажиллахыг;	Харьяа нутаг дэвсгэртээ үйл ажиллагаа явуулж байгаа ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, орон сууцны хорооллын гадна байрлах биеийн тамир, спортын болон тоглоомын талбай, ногоон байгууламжийг өдөр бүр 06:00-22:00 цагийн хооронд нээлттэй байлгаж, хүүхэд тоглох, ашиглах нөхцөлийг бүрдүүлэх чиглэлийг дүүргийн Биеийн тамир, спортын хороодод өгч ажиллахаас гадна биеийн тамир, спортын барилга байгууламж, заал, талбайг нээлттэй болгох тооцоо судалгаа гаргаж, хүртээмжийг тодорхойлох судалгааг дүүргийн Биеийн тамир, спортын хороодтой хамтран гүйцэтгэж Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлж ажилласан. Хэрэгжилт 100%	100%	-
9.	2	2023 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн А/727 дугаар захирамж Журам батлах тухай “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт зохион байгуулах журам”-ыг мөрдөж ажиллахыг;	Байгууллагын хэмжээнд дотоод хяналтын ажлын төлөвлөгөөг 14 ажил, арга хэмжээтэйгээр 2024 оны 01 дүгээр сарын 30-нд баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж 08 дугаар сард дотоод хяналт шалгалтыг хийж НЗДТГ-ын ХШҮ-ний газарт хүргүүлсэн. Дотоод хяналт шалгалтын үр дүнд 5 албан хаагчдад зөвлөмж өгч ажилласан. Хэрэгжилт 100%	100%	-
10.	1	2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн А/1430 дугаар захирамж Хуулийн хэрэгжилтийг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэл, ачааллыг бууруулах зорилгоор ажлын зайлшгүй шаардлагатайгаас бусад тохиолдолд нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын төрийн албан хаагчийг долоо хоногийн ажлын нэг өдөр зайнаас ажиллуулах хуваарь гаргаж, 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрөөс мөрдөж ажиллахыг;	Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын албан хаагчдыг ажлын нэг өдөр зайнаас ажиллуулахаар 2024 оны А/36 дугаар тушаалаар хуваарь гарган баталгаажуулан ажиллаж байна. Хуваарийн дагуу зайнаас ажиллах албан тушаалтнууд дотоод удирдлагын нэгдсэн систем ERP цаг бүртгэлийн системээр хүсэлтийг авч шийдвэрлэн ажилласан байна. Хэрэгжилт 100%	100%	-
		2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/01 дүгээр захирамж 2024 оныг “Тохижилт-Бүтээн байгуулалтын жил” болгон зарлах тухай Зорилтот жилийн хүрээнд хэрэгжүүлж байгаа арга хэмжээг Хариуцлагын гэрээ, гүйцэтгэлийн	2024 оныг “Тохижилт, бүтээн байгуулалтын жил” болгон зарласантай холбогдуулан нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй спортын заалтай барилга байгууламжийн судалгааг нэгтгэн гаргаж спортын барилга байгууламжийн хүртээмж 1000 хүнд 65 м2-д хүрснийг тодорхойлж гаргасан. Налайх дүүргийн 1-р хорооны нутаг		

11.	3	төлөвлөгөөнд тусгаж, шинэлэг шийдэл, инновац, технологи шингээсэн, стандартад нийцсэн тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлж, үйл ажиллагаагаа уялдуулан зохион байгуулж ажиллахыг;	дэвсгэрт баригдаж буй Спорт цогцолборын барилгын ажлыг “Бүрд констракшн” улсын төсвөөс 15.0 тэрбум төгрөгийн санхүүжилт авч 2012-2024 оны 08 дугаар сард 100% гүйцэтгэсэн. Мөн 2024 онд ерөнхий боловсролын 7 сургууль (Сонгинохайрхан дүүргийн 12, 169, Хан-Уул дүүргийн 10, Баянзүрх дүүргийн 14, Чингэлтэй дүүргийн 5, Баянгол дүүргийн бага сургууль цэцэрлэгийн цогцолбор, Налайх дүүргийн голомт цогцолбор) спортын заал баригдсан байна. Хэрэгжилт 100%	100%	-
12.	3	2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн А/59 дүгээр захирамж Нийслэлийн өвлийн спортын наадам зохион байгуулах тухай Арга хэмжээг 2024 оны 1 дүгээр улиралд багтаан зохион байгуулж ажиллахыг;	Өвлийн улиралд иргэдэд хүргэх биеийн тамир, спортын арга хэмжээ, ажил үйлчилгээг нэмэгдүүлж, өвлийн спортын төрлийг хөгжүүлж, тамирчдын ур чадварыг дээшлүүлэх зорилгоор Нийслэлийн өвлийн спортын наадмыг спортын 8 төрөл (мөсний шагайн харваа, виртуал дугуй, снөүбоард, тэшүүр, мөсөн сурын харваа, мөсөн авиралт, туялзуур сэлэм, дугуйт цана)-өөр зохион байгуулж 70 багийн 690 тамирчдыг хамруулсан. Дээрх арга хэмжээг зохион байгуулахдаа нийслэлийн төсвөөс 39,340,000(гучин есөн сая гурван зуун дөчин мянган) төгрөгийг зарцуулсан. Хэрэгжилт 100%	100%	-
13.	2	2024 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн А/185 дугаар захирамж Гадаад томилолтын тухай Гадаад томилолтоор ажилласан тухай тайланг ирсэн өдрөөс хойш 7 хоногийн дотор Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтэст ирүүлэхийг;	Биеийн тамир, спортын чиглэлээр гадаад арга хэмжээг өргөжүүлэх ажлын хүрээнд 2024 оны 03 дугаар сарын 04-нөөс 09-ний хооронд Бүгд найрамдах Солонгос улсын Сөүл хотын Жүдо бөхийн холбооны 80 жилийн ойн арга хэмжээнд оролцсон. Арга хэмжээний хүрээнд Сөүл хотын аварга шалгаруулах Жүдо бөхийн тэмцээн болон түүхт ойн арга хэмжээнд оролцож Монгол Улсын хэмжээнд Жүдо бөхийн хөгжил, тулгамдаж буй асуудлуудыг танилцуулж, илтгэл тавьсан. Гадаад томилолтоор ажилласан тухай тайланг хугацаанд нь хүргүүлсэн. Гадаад, дотоод зохион байгуулсан хурал, уулзалт, спортын уралдаан тэмцээн нийт 15 арга хэмжээнд 1351 хүн оролцсон. Хэрэгжилт 100%	100%	-
14.	1	2024 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн А/220 дугаар захирамж “Улаанбаатар лиг” сагсан бөмбөгийн тэмцээнийг зохион байгуулах тухай Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 02/10 дугаар тогтоолоор баталсан “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн	Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын бие бялдрыг чийрэгжүүлэх, хамтач үзэл санаа төлөвшүүлэх зорилгоор жил бүр зохион байгуулдаг “Улаанбаатар лиг” сагсан бөмбөгийн 2023-2024 оны хичээлийн жилийн тэмцээнийг 2023 оны 12 дугаар сарын 01-нээс 2024 оны 03 дугаар сарын 22-ны хооронд 3 насны ангиллаар 5 үе шаттай амжилттай зохион байгуулсан. Бага, дунд, ахлах насны ангилалд 9 дүүргийн ерөнхий боловсролын 192 сургуулийн	100%	-

		2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 2.2.2-т заасан зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын сагсан бөмбөгийн "Улаанбаатар лиг" тэмцээнийг 2024 оны 03 дугаар сарын 19-24-ний өдрүүдэд зохион байгуулахыг;	охид, хөвгүүдийн 8208 багийн 90550 мянга гаруй сурагч оролцсон бол шигшээ тэмцээнийг 2024 оны 03 дугаар сарын 18-22-ны өдрүүдэд Буянт-Ухаа спортын ордонд зохион байгуулж шат шатанд шалгарсан шилдэг 52 сургуулийн 96 багийн 1152 тамирчид өрсөлдөж аваргуудаа тодрууллаа. Тэмцээний ахлах насны ангилалд нэгдүгээр байр эзэлсэн эмэгтэй, эрэгтэй 2 багийг 2024 оны 09 дүгээр сард ОХУ-ын Школьная баскетбольная лига "КЭС-БАСКЕТ" Төрийн бус байгууллагаас зохион байгуулдаг бүх оросын сагсан бөмбөгийн тэмцээнд эх орноо төлөөлөн оролцох эрх олгосон. Хэрэгжилт 100%		
15.	1	2024 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн А/221 дүгээр захирамж "Улаанбаатар лиг" волейболын тэмцээнийг зохион байгуулах тухай Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 02/10 дугаар тогтоолоор баталсан "Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 2.2.2-т заасан зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын волейболын "Улаанбаатар лиг" тэмцээнийг 2024 оны 03 дугаар сарын 15-18-ны өдрүүдэд зохион байгуулахыг;	Нийслэлийн Засаг даргын нэрэмжит ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын "Улаанбаатар лиг" волейболын тэмцээнийг 2023 оны 12 дугаар сарын 01-нээс 2024 оны 04 дүгээр сарын 29-ний хооронд 2 насны ангиллаар, 3 үе шаттай зохион байгуулж 9 дүүргийн ерөнхий боловсролын 141 сургуулийн охид, хөвгүүдийн 520 багийн 67098 мянга сурагч оролцсон. Нийслэлийн шигшээ тэмцээнийг 2024 оны 04 дугаар сарын 26-29-ний өдрүүдэд Буянт-Ухаа спортын ордонд нийслэлийн шатанд дунд, ахлах насны шилдэг нийт 41 сургуулийн 64 багийн 832 тамирчид өрсөлдсөн бөгөөд тэмцээн зохион байгуулахад шаардагдах 45.745.000 төгрөгийг зориулалтын дагуу зарцуулсан. Хэрэгжилт 100%	100%	-
16.	1	2024 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн А/241 дүгээр захирамж "Улаанбаатар марафон-2024" олон улсын гүйлт зохион байгуулах тухай Гүйлтийн спортыг хөгжүүлэх, нийслэл хотоо дэлхийн улс орнуудад сурталчлах, гүйлтээр хичээллэгч сонирхогч иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор "Улаанбаатар марафон-2024" олон улсын гүйлтийг 2024 оны 05 дугаар сарын 25-ны Бямба гарагт зохион байгуулсугай.	"Улаанбаатар марафон-2024" олон улсын гүйлтийг 2024 оны 05 дугаар сарын 25-нд 7 зай 13 ангилал(42 км-т 18-аас дээш нас, ХБИ, гар дугуйн уралдаан, 21 км-т 18-34, 35-54, 55-аас дээш нас, ХБИ, 10 км-т 18-с дээш нас, 5 км-т 12-17 нас, 18-аас дээш насны эрүүл мэндийн гүйлт, 1,5 км (харааны бэрхшээлтэй, тэргэнцэртэй, гэр бүл), 500м, 800м-ийн зайг тусгай олимпын)-д ubmarathon.hipay.mn сайт, hipay.mn аппликейшнээр бүртгэж 22657 иргэд цахимаар, 7350 иргэн биеэр ирж бүртгүүлэн нийт 30000 тамирчин, иргэдийг хамруулсан. Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын байр, 9 дүүргийн Биеийн тамир, спортын хороодын байр, "Хай Пей" ХХК-ны байр, Д.Сүхбаатарын талбай, Улсын их дэлгүүрийн урд байрлах фантан нийт 13 бүртгэлийн штаб байгуулагдан оролцогчдыг бүртгэн, энгэрийн дугаар дагалдах хэрэглэлүүдийг олгосон. Гүйлт зохион байгуулах талаарх хэвлэлийн бага хурлыг 2 удаа зохион байгуулж, 5	100%	-

			<p>телевиз, 20 сайттай хамтран ажиллаж, гүйлтийн талаарх рийлс – 54, видео - 28, шторк - 1, зурагжуулсан мэдээлэл– 200 бэлтгэж 15 автобусны буудал, 75 явган хүний самбарт байршуулан, Баруун 4-н замаас Зүүн 4-н зам, талбайн 2 хажуу талын гэрлийн шонгууд дээр гүйлтийн туг, 8-н байршил дахь ЛЕД дэлгэцэд марафоны шторк байршуулж олон нийтэд сурталчилсан.</p> <p>Хэрэгжилт 100%</p>		
17.	2	<p>2024 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн А/241 дүгээр захирамж “Улаанбаатар марафон-2024” олон улсын гүйлт зохион байгуулах тухай “Улаанбаатар марафон-2024” олон улсын гүйлтийг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.</p>	<p>“Улаанбаатар марафон-2024” олон улсын гүйлтийг 2024 оны 05 дугаар сарын 25-нд 9 дэх жилдээ Д.Сүхбаатарын талбай, Сөүлийн гудамж, Партизаны гудамж, Бөмбөгөр худалдааны төвийн уулзвар, Төмөрчний гудамж, Гэсэр сүмийн уулзвар, Самбуугийн гудамж, Анкарагийн гудамж, Бага тойруу, Бээжингийн гудамж, Токиогийн гудамж, Сансарын туслах замаар Энхтайваны өргөн чөлөө, Зүүн дөрвөн замын уулзвараас Баруун дөрвөн замын уулзвар, Чагдаржавын гудамж, Элчингийн гудамж, Олимпын гудамж, Гэндэнгийн гудамж, Чингисийн өргөн чөлөө, Монголын хүүхдийн ордны уулзвараас Монгол шуудангийн уулзваруудын авто замын хөдөлгөөнийг бүрэн хааж зохион байгуулсан.</p> <p>Гүйлт зохион байгуулахаар 35 байгууллагын 46 албан хаагчдын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулагдаж 4 чиглэл 81 үйл ажиллагаа бүхий бэлтгэл ажлын төлөвлөгөөг баталж, ажлын хэсгүүд 1-3 удаа хуралдаж бэлтгэл ажлын төлөвлөгөө явцыг хэлэлцэж, үүрэг чиглэл өгч ажилласнаар хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан.</p> <p>Хэрэгжилт 100%</p>	100%	-
18.	1	<p>2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн А/460 дугаар захирамж Ажлын хэсэг байгуулах тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжиж буй “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөнийг нийслэл Улаанбаатар хотод эрчимжүүлж, иргэдийн эрүүл мэндийг сайжруулах, өвчлөл, эндэгдэлд хүргэж буй эрсдэлт хүчин зүйлийг бууруулах, амьдралын зөв дадал, хэвшлийг бий болгох арга хэмжээ авч хэрэгжүүлэх уг арга хэмжээг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр, үйл ажиллагааны удирдамжийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.</p>	<p>Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжиж буй “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний хүрээнд иргэдэд эрүүл идэвхтэй амьдралын хэв маягийг төлөвшүүлэхээр 18 арга хэмжээ бүхий бэлтгэл ажлын төлөвлөгөө баталж жилийн эцсийн байдлаар биелэлт 100 хувьтай байна.</p> <p>Нийслэл, дүүргийн хэмжээнд 2024 онд нийтийн биеийн тамирын 345 арга хэмжээ зохион байгуулж 8909 байгууллагын 888,500 иргэнийг хамруулсан.</p> <p>Хэрэгжилт 100%</p>	100%	-

19.	1	<p>2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн А/465 дугаар захирамж Журам шинэчлэн батлах тухай Захирамжлалын баримт бичиг гаргах ажиллагааны журмыг 1 дүгээр, Хяналтын дагалдах хуудасны загварыг 2 дугаар, Төсөлд ирүүлсэн саналын товъёгийн загварыг 3 дугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.</p>	<p>Захирамжлалын баримт бичиг гаргах журмыг баримтлан биеийн тамир, спортын чиглэлээр 2024 онд 20 захирамж үүнээс төсөвтэй 12 захирамж гарч хэрэгжилтийг бүрэн ханган ажилласан.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт 100%</p>	100%	-
20.	1	<p>2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн А/483 дугаар захирамж Хөлбөмбөгийн тэмцээн зохион байгуулах тухай Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 он 02/10 дугаар тогтоолоор баталсан “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.2.1, 2.2.2-т заасан зорилт уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.2.1.4, 2.2.2.2-т заасан арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор Нийслэлийн иргэдийн дунд хөлбөмбөгийн “Улаанбаатар цом” тэмцээнийг 2024 оны 05 дугаар сарын 20-26-ны өдрүүдэд, Нийслэлийн Ерөнхий боловсролын сургуулиудын дунд зохион байгуулагдах хөлбөмбөгийн “Мөрөөдлийн гоол” тэмцээнийг 2024 оны 05 дугаар сарын 06-ны өдрөөс 15-ны өдрүүдэд тус тус зохион байгуулахыг Нийслэлийн Биеийн тамир, спортын газар (Ж.Ганболд)-т даалгасугай.</p>	<p>Нийслэлийн иргэдийн дунд “Улаанбаатар цом” хөл бөмбөгийн тэмцээнийг 2024 оны 05 дугаар сарын 19-23-ны өдрүүдэд Монголын хөл бөмбөгийн холбоотой хамтран зохион байгуулж 7 дүүргийн 98 тамирчид оролцсон. Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд “Мөрөөдлийн гоол” хөлбөмбөгийн тэмцээнийг Монголын Хөлбөмбөгийн холбоотой хамтран зохион байгуулж 2024 оны 03 дугаар сараас 05 дугаар сарын 17-ны хооронд 6 насны ангиллаар зохион байгуулж 66 багийн 1000 гаруй хүүхэд, багачууд хамрагдсан.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт 100%</p>	100%	-
21.	1	<p>2024 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн А/546 дугаар захирамж “Улаанбаатар Урбан фестиваль” сагсан бөмбөгийн 3x3 олон улсын тэмцээнд дэмжлэг үзүүлэх тухай Сагсан бөмбөгийн спортыг хөгжүүлэх, олимпын эрх олгох, нийслэл хотоо дэлхийн улс орнуудад сурталчлах зорилгоор “Улаанбаатар Урбан фестиваль” сагсан бөмбөгийн 3x3 олон улсын тэмцээнийг “Монголын 3x3 сагсан бөмбөгийн холбоо”-той хамтран 2024 оны 06 дугаар сарын 04-10-ны өдрүүдэд зохион байгуулж ажиллахыг Нийслэлийн Биеийн тамир, спортын газар (Ж.Ганболд)-т үүрэг болгосугай.</p>	<p>“Улаанбаатар Урбан фестиваль” сагсан бөмбөгийн 3x3 олон улсын тэмцээнийг Монголын 3x3 сагсан бөмбөгийн холбоотой хамтран 2024 оны 06 дугаар сарын 06-наас 09-ний өдрүүдэд Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулж фестивалийн зохион байгуулагдсан арга хэмжээ, тэмцээн уралдаанд 4160 тамирчин, хүүхэд, багачууд, иргэд оролцсон. Үүнд: ✓ Фиба 3x3 дэлхийн эмэгтэйчүүдийн Гран При Улаанбаатар - 2024 сагсан бөмбөгийн олон улсын тэмцээнийг 2024 оны 06 дугаар сарын 06, 07-ны өдрүүдэд зохион байгуулж Австри, Хятад, Филиппин, Тайланд, Украин, Монгол Улсын 8 багийн 32 тамирчин оролцож Монгол Улсын шигшээ баг Дэлхийн Гран При аваргаар шалгарсан. ✓ Фиба 3x3 Улаанбаатарын Дэлхийн Дуулга 2024 сагсан бөмбөгийн олон улсын тэмцээнийг 2024 оны 06 дугаар сарын 08, 09-ний өдрүүдэд зохион байгуулж олон улсын 12 багийн</p>	100%	-

			48 тамирчин оролцож Амстердам улсын баг Улаанбаатарын Дэлхийн Их Дуулгын аваргаар шалгарав. Фестивалийн хүрээнд кроссфит, корнхолл, скайтбоардинг, BMX Дугуй, Лазер гүйлт, 3x3 сагсан бөмбөг, модон барилдаан, гудамжны крикет спортын төрлүүдээр нээлттэй тэмцээн зохион байгуулагдаж 4080 сонирхогч, хүүхэд, багачууд оролцсон. Хэрэгжилт 100%		
22.	1	2024 оны 05 дугаар сарын 17-ны өдөр А/574 дүгээр захирамж "Улаанбаатар марафон-2024" олон улсын гүйлтийг зохион байгуулах талаар авах зарим арга хэмжээний тухай "Улаанбаатар марафон-2024" олон улсын гүйлт зохион байгуулагдахтай холбогдуулан гүйлтийн маршрутын дагуу хэсэгчилсэн авто замын хөдөлгөөнийг хааж, дүүргийн иргэдэд үйлчилгээ үзүүлэх байршил, үйл ажиллагааны чиглэлийг 1 дүгээр, тухайн өдөр амрах зарим зах, худалдаа, үйлчилгээний төвийн жагсаалтыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.	"Улаанбаатар марафон-2024" олон улсын гүйлтийг 2024 оны 05 дугаар сарын 25-нд 9 дэх жилдээ Д.Сүхбаатарын талбай, Сөүлийн гудамж, Партизаны гудамж, Бөмбөгөр худалдааны төвийн уулзвар, Төмөрчний гудамж, Гэсэр сүмийн уулзвар, Самбуугийн гудамж, Анкарагийн гудамж, Бага тойруу, Бээжингийн гудамж, Токиогийн гудамж, Сансарын туслах замаар Энхтайваны өргөн чөлөө, Зүүн дөрвөн замын уулзвараас Баруун дөрвөн замын уулзвар, Чагдаржавын гудамж, Элчингийн гудамж, Олимпын гудамж, Гэндэнгийн гудамж, Чингисийн өргөн чөлөө, Монголын хүүхдийн ордны уулзвараас Монгол шуудангийн уулзваруудын авто замын хөдөлгөөнийг хааж амжилттай зохион байгуулсан. Хэрэгжилт 100%	100%	-
23.	2	2024 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн А/616 дугаар захирамж Ажлын хэсэг байгуулах тухай "Даншиг наадам-Хүрээ цам" шашин соёлын наадмыг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор баталсугай.	2024 оны 08 дугаар сарын 03, 04-ний өдрүүдэд Хүй долоо худагт зохион байгуулагдсан "Даншиг наадам хүрээ цам" шашин соёлын наадмын бөхийн барилдааныг Монголын Үндэсний бөхийн холбоо, Үндэсний сурын харвааг Монголын Үндэсний сурын харваатай хамтран зохион байгуулсан. Даншиг даадмын үндэсний бөх, Өвөр Монгол бөх, Буриад бөхийн барилдааныг зохион байгуулах жаяг дэгийн баг (ерөнхий хөлийн цэц, хөлийн цэцүүд, гарын даа нар, засуулууд, эмч, тайлбарлагч гэх мэт)-ийг Үндэсний бөхийн холбооноос бүрдүүлж өгсөн. Бөхийн барилдааны хүрээнд Өвөрмонгол 64 бөх, Буриад 64 бөх, Үндэсний 246 бөх оролцож бяра хүчээ сорин өрсөлдсөн. Монголын бурхан шашинтны төв гандантэгчэнлин хийдийн тэргүүн Хамбын шийдвэрээр 5 давж шөвгөрсөн Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын харьяат аймгийн арслан Ядамсүрэнгийн Бумбаяр, Говь-Алтай аймгийн Тонхил сумын харьяат улсын өсөх идэр начин Балжиннямын Суманчулуун, Өмнөговь аймгийн Ханхонгор сумын харьяат улсын заан Цэдэнбазарын Одбаяр, Архангай аймгийн Цэнхэр сумын харьяат улсын начин Эрдэнэцогтын Ванданцэрэн нарт Даншигийн "Начин" цолыг тус тус олгож үнэмлэх, тэмдгийг гардуулсан бол 6 давсан Баянхонгор аймгийн Жинст сумын харьяат улсын начин	100%	-

			Энхтүвшиний Батмагнай, Архангай аймгийн Ихтамир сумын харьяат Аймгийн арслан Сампилын Цогтбаатар нарт Монголын бурхан шашинтны төв гандантэгчэнлин хийдийн тэргүүн Хамбын шийдвэрээр өсөх идэр "Начин" цолыг тус тус олгосон. Хэрэгжилт 100%		
24.	2	2024 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн А/1048 дугаар захирамж "Автомашингүй өдөр-2024" нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах тухай "Автомашингүй өдөр-2024" нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр, энэ өдөр амрах томоохон зах, худалдаа, үйлчилгээний төвийн жагсаалтыг 2 дугаар, дүүргээс иргэдэд үйлчилгээ үзүүлэх байршил, үйл ажиллагааны чиглэлийг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/1048, А/1086 дугаар захирамж, Автомашины хэрэглээнээс үүдэлтэй сөрөг нөлөөг багасгахад олон нийтийн анхаарлыг хандуулах зорилгоор "Автомашингүй өдөр" нэгдсэн арга хэмжээний хүрээнд Нийслэлийн Биеийн тамир, спортын газар, Монголын спорт, сонирхогчдын хөгжөөн дэмжигчдийн холбоо, Монголын ширээний шагайн холбоо, Монголын ширээний теннисний холбоо, Монголын дартс сонирхогчдын холбоо, Нийслэлийн 9 Дүүргийн Биеийн тамир, спортын хороодтой хамтран 2024 оны 09 дүгээр сарын 21-ний өдөр Биеийн тамир, спортын өдөрлөгийг зохион байгуулсан. Өдөрлөгийн хүрээнд Нийслэлийн хэмжээнд 25 биеийн тамир, спортын арга хэмжээ зохион байгуулж 1800 иргэд оролцсон. Нийслэлийн Биеийн тамир, спортын газар, Монголын спорт, сонирхогчдын хөгжөөн дэмжигчдийн холбоо, Монголын ширээний шагайн холбоо, Монголын ширээний теннисний холбоо, Монголын дартс сонирхогчдын холбоо, Багахангай, Багануур, Налайх дүүргийн Биеийн тамир, спортын хороод жанжин Д.Сүхбаатарын талбайд 11 асарт иргэдэд ажил үйлчилгээгээ сурталчилж, Спорт бүжгийн тэмцээн, Үндэсний шагайн тэмцээн, даамны тэмцээн зохион байгуулсан. Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/1086 дугаар захирамжийн дагуу 7.535.000 төгрөгийн санхүүжилт авч Монголын спорт сонирхогчдын хөгжөөн дэмжигчдийн холбоотой 2024 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр 6.935.000 ажил гүйцэтгэх гэрээ байгуулан ажилласан. Хэрэгжилт 100%	100%	-
25	1	2024 оны 11 сарын 15 өдрийн А/1363 дугаар захирамж Нийслэлийн иргэдийн спортын XII наадам зохион байгуулах тухай	Монгол Улсын Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйл, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/1363 дугаар захирамж, "Эрүүл Монгол хүн" хөтөлбөр, "Соёлын бүтээлч аян"-ы хүрээнд Нийслэлийн Иргэдийн спортын XII наадмыг 2024 оны 07 дугаар сараас 11		

			дүгээр сарын 27-ны хооронд спорт явган аялал, олс таталт, сагсан бөмбөг, волейбол, софт волейбол, хийн дасгал, аэробик, ширээний шагайн наадгай, дартс гэсэн спортын 9 төрлөөр 5 үе шат (хэсэг, хороо, бүс, дүүрэг, нийслэл)-тайгаар амжилттай зохион байгуулсан. Нийслэлийн Иргэдийн спортын XII наадамд нийт 9 дүүргийн 204 хорооны 90100 иргэн оролцсоноос шигшээ тэмцээнд 71 хорооны 124 багийн 1044 иргэн оролцсон. Хэрэгжилт 100%	100%	-
Хэсгийн дундаж			100%		
4.НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС					
26.	1A	2024.01.09-ний 01 дүгээр хуралдааны тэмдэглэлээс Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, харьяа газрууд байгууллагын веб сайтаа шинэчилж баяжуулах, англи хэл дээр хувилбартай болгон 7 хоног бүр мэдээллээ шинэчилж ажиллахыг;	Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам"-ын дагуу байгууллагын www.it@sport.ub.gov.mn цахим хуудсаар 2024 онд зохион байгуулсан биеийн тамир, спортын 45-н ажил, үйлчилгээний 65 мэдээг байршуулж 8,083 хүнд, Нийслэлийн Биеийн тамир, спортын газар пэйж хуудсанд 300 мэдээлэл байршуулж 91156 хүнд хүргэж, 17069 дагагчтай болсон. 2024 онд 165 удаагийн рийл хийж, 270,490 удаа үзсэн байна. Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаа, цаг үеийн шаардлагатай мэдээ, мэдээллийг 1150 удаа хувь хүн, албан байгууллагатай цахим шуудангаар солилцсон. Хэрэгжилт 100%	100%	-
27.	1	2024.01.09-ний 01 дүгээр хуралдааны тэмдэглэлээс Иргэдээс нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хууль зүйн үндэслэлтэй, шуурхай, нэг мөр эцэслэн шийдвэрлэх, хариуг албан бичгээр өгч хэвшихийг;	Төрийн үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлэхээр иргэдийг цайны цагаас бусад бүх цагт хүлээн авахаар хуваарь баталж 2024 оны жилийн эцсийн байдлаар 18 иргэний 15 хүсэлтийг шийдвэрлэсэн бол иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх хугацааг 4 хоног 9 цаг 37 минут болж өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн хугацаа өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1 хоногоор бууруулсан. Хэрэгжилт 100%	100%	-
28.	2	2024.01.09-ний 01 дүгээр хуралдааны тэмдэглэлээс Иргэдээс гаргасан гомдлын агуулга, шалтгаан нөхцөлийг бодитой тодорхойлж, гомдлыг бууруулах чиглэлээр шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэн, үр дүнг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт улирал тутам тайлагнаж ажиллахыг;	Төрийн үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлэхээр иргэдийг цайны цагаас бусад бүх цагт хүлээн авахаар хуваарь баталж 2024 оны жилийн эцсийн байдлаар 18 иргэний 15 хүсэлтийг шийдвэрлэсэн бол иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх хугацааг 4 хоног 9 цаг 37 минут болж өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн хугацаа өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1 хоногоор бууруулж ажилласан байна Өргөдөл, гомдлын I улирлын тайланг 2024 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 02/90 дугаар албан бичгээр хүргүүлж ажилласан бол хагас жилийн тайланг 2024 оны 06 дугаар сарын 27-ны 02/163 дугаар албан бичгээр хүргүүлсэн бөгөөд	100%	-

			гуравдугаар улирлын тайланг 2024 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр 02/209 дүгээр албан бичгээр жилийн эцсийн тайлан мэдээний хэрэгжилтийг хүргүүлэхээр бэлтгэсэн. Хэрэгжилт 100%		
29.	3	2024.01.09-ний 01 дүгээр хуралдааны тэмдэглэлээс Иргэдээс төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гаргасан гомдлыг түүнд холбогдож байгаа албан тушаалтанд өөрт нь шилжүүлэн, шийдвэрлэхгүй байхыг;	Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын Ёс зүйн дүрмийг шинэчлэхээр боловсруулалтын ажил хийгдэж байгаа бөгөөд 2024 онд ёс зүйн чиглэлээр ёс зүйн зөрчил гаргасан албан хаагч болон иргэд, аж, ахуйн нэгж байгууллагаас албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол ирээгүй байна. Хэрэгжилт 100%	100%	-
30.	4	2024.01.09-ний 01 дүгээр хуралдааны тэмдэглэлээс Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн шат дамжлага, дундаж хугацаа, зөрчлийн үзүүлэлтийг бууруулах, шийдвэрлэлтийг сайжруулах чиглэлээр тусгай төлөвлөгөө боловсруулан, хэрэгжилтийг үр дүнтэй хангаж ажиллахыг;	Төрийн үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлэхээр иргэдийг цайны цагаас бусад бүх цагт хүлээн авахаар хуваарь баталж 2024 оны жилийн эцсийн байдлаар 18 иргэний 15 хүсэлтийг шийдвэрлэсэн бол иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх хугацааг 4 хоног 9 цаг 37 минут болж өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн хугацаа өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1 хоногоор бууруулж ажилласан байна Хэрэгжилт 100%	100%	-
31.	8	2024.01.09-ний 01 дүгээр хуралдааны тэмдэглэлээс Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль болон Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журмын дагуу өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан мэдээг улирал бүр байгууллагын цахим хуудсанд байршуулж хэвшихийг;	Төрийн үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлэхээр иргэдийг цайны цагаас бусад бүх цагт хүлээн авахаар хуваарь баталж 2024 оны жилийн эцсийн байдлаар 18 иргэний 15 хүсэлтийг шийдвэрлэсэн бол иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх хугацааг 4 хоног 9 цаг 37 минут болж өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн хугацаа өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1 хоногоор бууруулж ажилласан байна Өргөдөл, гомдлын I улирлын тайланг 2024 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 02/90 дугаар албан бичгээр хүргүүлж ажилласан бол хагас жилийн тайланг 2024 оны 06 дугаар сарын 27-ны 02/163 дугаар албан бичгээр хүргүүлсэн бөгөөд гуравдугаар улирлын тайланг 2024 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр 02/209 дүгээр албан бичгээр жилийн эцсийн тайлан мэдээний хэрэгжилтийг хүргүүлэхээр ажиллаж байна. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн ил тод, нээлттэй байдлыг ханган https://sport.ub.gov.mn/ сайтын мэдээллийн “ил тод, нээлттэй байдал” дэд хэсэгт байршуулсан. Хэрэгжилт 100%	100%	-
32.	9	2024.01.09-ний 01 дүгээр хуралдааны тэмдэглэлээс Иргэдээс гаргасан өргөдөл, гомдолд дүн шинжилгээ хийж, 7 хоног бүрийн тайлан мэдээг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт тогтоосон хугацаанд ирүүлэх, иргэдийн гомдлыг бүрэн барагдуулж шийдвэрлэхэд байгууллагын үйл ажиллагааны зохион байгуулалт, төсөв санхүү, хөрөнгийн нөөц, эрх зүйн	Биеийн тамир, спортын чиглэлээр иргэдээс нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг 17 эх үүсвэрээр хүлээн авах зохицуулалтын дагуу 2024 оны жилийн эцсийн байдлаар байдлаар 18 иргэний 15 хүсэлтийг шийдвэрлэсэн бол иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх хугацааг 4 хоног 9 цаг 37 минут болж өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн	100%	-

		орчны нөлөөлөл, хүчин зүйлийн үнэлгээ хийж, танилцуулж шийдвэрлүүлэхийг;	хугацаа өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1 хоногоор бууруулж ажилласан байна. Хэрэгжилт 100%		
33.	5	2024.01.09-ний 01 дүгээр хуралдааны тэмдэглэлээс Хотын хөгжлийн индексийг тооцон үнэлэхтэй холбогдуулан хариуцсан чиг үүргийн дагуу холбогдох индексийн үзүүлэлтийг үйл ажиллагаандаа уялдуулж, сайжруулах талаар арга хэмжээ авч ажиллахыг;	Нийслэлийн Биеийн тамир, спортын газар нь Хотын хөгжлийн "Спортын хүртээмж" буюу 53 индексийн үзүүлэлтэд хамрагдаж Нийслэлийн Биеийн тамир, спортын газар нь Хотын хөгжлийн "Спортын хүртээмж" буюу 53 индексийн үзүүлэлтэд хамрагдаж 2024 онд индексийг сайжруулах хийгдэх ажлын төлөвлөгөөг боловсруулж 2024 оны 05 дугаар сарын 20-нд Бодлогын судалгаа, шинжилгээний төвд хүргүүлсэн. Мөн Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын 2024 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 02/225 дугаар албан бичгээр хотын хөгжлийн индекс тооцход хамаарах үзүүлэлтийн статистик тоон мэдээллийг Бодлогын судалгаа, шинжилгээний төвд хүргүүлж ажиллаа. Тухайн төлөвлөгөөний биелэлт 90 хувьтай хэрэгжиж байна. Хэрэгжилт 90%	90%	-
Хэсгийн дундаж			99%	99%	
5.НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН АЛБАН ДААЛГАВАР					
34.	1	2024.03.19-ний 01 дүгээр албан даалгавар Худалдан авах ажиллагааны талаар авах зарим арга хэмжээний тухай Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хуулийн дагуу шуурхай зохион байгуулж, явц, үр дүнг ил тод мэдээлж ажиллах	2024 онд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй бөгөөд шууд худалдан авах төсөвт өртгийн босго үнийг баримтлан гэрээ байгуулан ажиллаж байна. Харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн хязгаарыг баримтлан 20 сая дээш үнийн дүнтэй 6 ажлын мэдээллийг Авлигатай тэмцэх газарт хүргүүлж ажилласан. Хэрэгжилт 100%	100%	-
35.	1	2024.09.19-ны 03 дугаар албан даалгавар Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлж, санхүүгийн сахилга хариуцлагыг баримтлан ажиллах тухай Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулан, хэмнэлтийг чанд сахин ажиллах	2024 онд 653,414,900 төгрөгийн санхүүжилт батлагдсан. 12-р сарын 13-ны байдлаар үйл ажиллагааны урсгал зардалд 598,711,993,51 төгрөг зарцуулснаас албан хаагчдын цалинд 71% буюу 425,522,100.00 төгрөг бусад зардалд 29% буюу 175,888,300.00 төгрөгийн зардлыг хуваарь зориулалтын дагуу зарцуулсан байна Санхүүгийн үйл ажиллагаанд төсөв, санхүүгийн сахилга батыг чанд мөрдөж, төсвийн зардлыг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулж тайлан мэдээг тухай бүр хугацаанд нь хүргүүлэн ажилласан. Хэрэгжилт 90%	90%	-
Хэсгийн дундаж					
Нийслэлийн Биеийн тамир, спортын газар нь 2024 онд 35 шийдвэрийн 35 заалтыг буюу Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн 3 тогтоолын 3 заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2 тогтоолын 2 заалт, Нийслэлийн Засаг даргын 20 захирамжийн 20 заалт, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлаар өгөгдсөн 8 үүрэг даалгавар, 2 албан даалгаврын 2 заалтыг хяналтад авч 97.9 хувьтай Монгол Улсын Засгийн газрын 206 дугаар тогтоолын 6 дугаар зүйлийн 6.3-т заасан аргачлалын дагуу "бүрэн хэрэгжсэн" буюу 98 хувьтай гэж үнэллээ.					

ТАНИЛЦСАН:
НИЙСЛЭЛИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

С.САРАНЦЭЦЭГ

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТ, САНХҮҮГИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

М.ЦОГЗОЛМАА



ТАЙЛАН НЭГТГЭСЭН:
ЭРХ ЗҮЙ, ТОГТООЛ ШИЙДВЭР
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Н.СҮНЖИДМАА

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
ХҮНИЙ НӨӨЦ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН

Б.ОЮУНТУЯА

НИЙСЛЭЛИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗАР

ДАРГЫН ДЭРГЭДЭХ УДИРДЛАГЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2024 оны 12 дугаар сарын 16

Дугаар 15

Улаанбаатар хот

Даргын дэргэдэх Удирдлагын зөвлөлийн ээлжит хурал 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 16:40 минутаас Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын цогцолбор барилгын “Б” блок 11 давхар 1116 тоот тоот өрөөнд болж 17:50 минутад өндөрлөв.

Хурлыг Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Саранцэцэг удирдан явуулж, Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн дарга М.Цогзолмаа, Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Г.Бямбасайхан, Хүний нөөц хариуцсан мэргэжилтэн Б.Оюунтуяа, нарийн бичгээр Эрх зүй, тогтоол шийдвэр хариуцсан мэргэжилтэн Н.Сүнжидмаа нар оролцсон.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:

Бодлогын баримт бичгүүдийн 2024 оны биелэлт болон хяналтад авагдсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг танилцуулах

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Бодлогын баримт бичгүүдийн 2024 оны биелэлт болон хяналтад авагдсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн ажлын тайланг хэлэлцэх.

Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн ахлах мэргэжилтэн
Г.Бямбасайхан
Эрх зүй, тогтоол шийдвэр хариуцсан мэргэжилтэн
Н.Сүнжидмаа

СОНССОН НЬ:

С.Саранцэцэг: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Бодлогын баримт бичгүүдийн 2024 оны биелэлтэнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн ажлын товч танилцуулгыг Г.Бямбасайхан хийнэ.

Г.Бямбасайхан: - Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл 1 зорилт 5 ажлын дундаж 100%

- Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө 1 зорилт 2 үйл ажиллагаа 100%

- Алсын хараа-2050 урт хугацааны бодлогын баримт бичиг 3 зорилт 4 арга хэмжээ 80%

- Нийслэлийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөө 7 зорилт 9 арга хэмжээ 96.6%

- Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр 90%

- Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл 98.6-тай тус тус үнэлэгдсэн байна.

Б.Оюунтуяа: Олон улсын жишигт нийцсэн 30,000-40,000 хүний суудалтай цэнгэлдэх хүрээлэн барьж байгуулах заал 30%-тай үнэлэгдсэн байна. Бусад заалт 90-с дээш үнэлгээтэй байгаа.

С.Саранцэцэг: Хяналтад авагдсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг Н.Сүнжидмаа танилцуулна.

Н.Сүнжидмаа: - Нийслэлийн Биеийн тамир, спортын газар нь 2024 онд 24 хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн 51 заалтыг хяналтад авч хэрэгжилтийн дундаж 100 хувьтай үргэлжилж байгааг Монгол Улсын Засгийн газрын 206 дугаар тогтоолын 6 дугаар зүйлийн 6.3-т заасан аргачлалын дагуу “бүрэн хэрэгжсэн” буюу 99 хувьтай

- Засгийн газрын new.unelgee.gov.mn програмд оруулах хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2024 оны жилийн эцсийн байдлаар тайлангийн 8 заалтын хэрэгжилтийн дундаж 96 хувьтай байгааг Монгол Улсын Засгийн газрын 206 дугаар тогтоолын 6 дугаар зүйлийн 6.3-т заасан аргачлалын дагуу “бүрэн хэрэгжсэн” буюу 96 хувьтай

- Захирамжлалын баримт бичигт 2024 онд 35 шийдвэрийн 35 заалтыг буюу Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн 3 тогтоолын 3 заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2 тогтоолын 2 заалт, Нийслэлийн Засаг даргын 20 захирамжийн 20 заалт, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлаар өгөгдсөн 8 үүрэг даалгавар, 2 албан даалгаврын 2 заалтыг хяналтад авч 97.9 хувьтай Монгол Улсын Засгийн газрын 206 дугаар тогтоолын 6 дугаар зүйлийн 6.3-т заасан аргачлалын дагуу “бүрэн хэрэгжсэн” буюу 98 хувьтай тус тус үнэлэгдсэн байна.

С.Саранцэцэг: Үнэлгээнд өөрчлөлт орсон заалт байгаа юу?

Б.Оюунтуяа: Байхгүй дарга

С.Саранцэцэг: Дээрх ажлын хэрэгжилттэй холбоотой асуулт, саналтай гишүүн байна уу?

М.Цогзолмаа: Байхгүй ээ дарга. Манай 2024 оны жилийн эцсийн үйл ажиллагаа сайн үнэлэгдсэн байна.

С.Саранцэцэг: Өөр асуулт, саналтай гишүүн байхгүй бол өнөөдрийн хурлаа өндөрлөө.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Бодлогын баримт бичгүүдийн 2024 оны биелэлт болон хяналтад авагдсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн үнэлгээг хэвээр үлдээж шийдвэрлэв.

Хурал 17:50 минутад өндөрлөв.

ТАНИЛЦСАН:

ДАРГЫН ДЭРГЭДЭХ УДИРДЛАГЫН
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

С.САРАНЦЭЦЭГ

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

ДАРГЫН ДЭРГЭДЭХ УДИРДЛАГЫН ЗӨВЛӨЛИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Н.СҮНЖИДМАА

